



САНГИЙН ЯАМ



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
НЭГ. УДИРТГАЛ	4
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ	7
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ	9
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт ...	9
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт	13
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт.....	15
3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зохицуулалт	18
ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	19
4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	19
4.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	31
4.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	44
4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	52
ТАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ	55
ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	57
ДОЛОО. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	62

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	10
Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	13
Хүснэгт 3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	15
Хүснэгт 4. Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгсэл.....	19
Хүснэгт 5. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төсөвт өртгийн судалгаа.....	21
Хүснэгт 6. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санал (төслийн ангиллаар)	25
Хүснэгт 7. Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ.....	37
Хүснэгт 8. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ	38
Хүснэгт 9. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байдал	51
Хүснэгт 10. Хуулийн төслийг харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	52

НЭГ. УДИРТГАЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоолоогүй үр дагаврыг тодорхойлох, хуулийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх, хуулийн төслийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон төслийн боловсруулалтыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д¹ /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар үнэлсэн. Үүнд:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хамтран баталсан байх бөгөөд уг хуулийн төслийг 2025.11.22-ны өдрийн байдлаар 8 бүлэг 52 зүйлтэй боловсруулсан байна.

Хуулийн төсөлд “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн зорилго нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино” гэж заажээ.

Хуулийн төслийг дараах бүтэцтэй боловсруулсан байна. Үүнд:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1 дүгээр зүйл.Хуулийн зорилго
- 2 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хууль тогтоомж
- 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
- 4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт
- 5 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчим
- 6 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын үе шат
- 7 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл
- 8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цаглавар
- 9 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйл

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

- 10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх
- 11 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх
- 12 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
- 13 дугаар зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх
- 14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх
- 15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх
- 16 дугаар зүйл.Захиалагчийн чиг үүрэг

ГУРАВДУГААР БҮЛЭГ.ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 17 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, тэргүүлэх салбар
- 18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт
- 19 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах шаардлага
- 20 дугаар зүйл.Төслийн төлөвлөлт, бэлтгэл ажлыг хангах
- 21 дүгээр зүйл.Техник, эдийн засгийн үндэслэл
- 22 дугаар зүйл.Техник, эдийн засгийн үндэслэлийн тайлан
- 23 дугаар зүйл.Төслийн нийгмийн ач холбогдол болон эдийн засгийн үр ашиг
- 24 дүгээр зүйл.Төслийг үнэлж, эрэмбэлэх
- 25 дугаар зүйл.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, үнэлэх, шийдвэрлэх
- 26 дугаар зүйл.Төслийг төсөвт тусгах

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮЖИЛТ, ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

- 27 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт
- 28 дугаар зүйл.Эрх шилжүүлэх, багц хуваарилах
- 29 дүгээр зүйл.Төслийн гэрээний удирдлага
- 30 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт
- 31 дүгээр зүйл.Төслийн санхүүжих дүнд хийх хөрөнгийн зохицуулалт
- 32 дугаар зүйл.Төслийн хэрэгжилтэд тавих хяналт
- 33 дугаар зүйл.Төсөвт өртгийн зохицуулалт
- 34 дүгээр зүйл.Тайлагналт, үр дүн

ТАВДУГААР БҮЛЭГ.ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ЦАХИМ СИСТЕМИЙН УДИРДЛАГА

- 35 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сан, ил тод, нээлттэй байдал
- 36 дугаар зүйл.Олон нийтийн оролцоо
- 37 дугаар зүйл.Цахим системийн удирдлага, зохион байгуулалт

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, АШИГЛАЛТ, ТҮҮНИЙ ҮР ӨГӨӨЖ

- 38 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн удирдлага
- 39 дүгээр зүйл.Хөрөнгийн бүртгэл, өмчлөл

- 40 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сан
- 41 дүгээр зүйл.Хөрөнгийн ашиглалт, сайжруулалт
- 42 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн үр өгөөж

ДОЛООДУГААР БҮЛЭГ.ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН

САН

- 43 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан
- 44 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн эх үүсвэр
- 45 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн хөрөнгийн зарцуулалт
- 46 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн ил тод байдал, тайлагналт
- 47 дугаар зүйл.Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

НАЙМДУГААР БҮЛЭГ.БУСАД ЗҮЙЛ

- 48 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх
- 49 дүгээр зүйл.Хохирол, гэм хор нөхөн төлүүлэх
- 50 дугаар зүйл.Хариуцлага хүлээлгэх үндэслэл
- 51 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
- 52 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Практикт хэрэгжих боломж;
- 3.Ойлгомжтой байдал;
- 4.Харилцан уялдаа зэрэг болно.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн зорилгод тодорхойлсон харилцаанд хамаарах зохицуулалтаас зорилго бүрээр сонгосон зүйл, хэсэг, заалтын хүрээнд	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслөөс сонгосон зохицуулалтын хүрээнд	Хуулийн төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт практикт хэрэгжих боломжтой эсэхийг холбогдох хуулийн зохицуулалт хоорондын уялдаа, хэрэгжилтийн практик, мэргэжилтнүүдийн санал, дүгнэлтэд тулгуурлан дүн шинжилгээ хийх
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслөөс сонгосон зохицуулалтын хүрээнд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд	Хуулийн төслийн харилцан уялдааг Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуултаар шалгах

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүрэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох Тандан судалгааны тайлан, Олон улсын харьцуулсан судалгааны тайлантай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судалсны үндсэн дээр хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэсэн, зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтыг сонгосон болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг урьдчилан тогтоох ба ингэхдээ цаг хугацааны боломж хомс байсан тул хэлэлцүүлэг, судалгааны ажлаас гаргасан санал, зөвлөмж, талуудын байр суурийг харгалзан үзэх замаар үнэлэх боломжтой гэж үзэв.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн зохицуулалтаас сонгосон зүйл, хэсэг, заалтын бичвэр, боловсруулалт нь хуулийн үр дагаврын зохицуулалтын хувьд ойлгомжтой, зөрчилгүй бичигдсэн эсэх, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэх, хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдэд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлнэ.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Үнэлгээний ажлын энэ хэсэгт аргачлалд заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг сонгох буюу тогтоож, өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тохируулан бэлтгэх юм. Хуулийн төслийн үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг сонгохдоо хууль зүйн үр дагавар шууд үүсгэж байгаа буюу голлох ач холбогдолтой, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай зохицуулалтыг сонгож авсан болно.

Тодруулбал, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг, хууль зүйн үр дагавар үүсгэж буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудал дагуулах магадлалтай, анхаарах шаардлагатай зохицуулалтыг сонгож, сонгосон зүйл, заалтын үр нөлөөг үнэлэх болно. Шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тоймловол:

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хууль, эрх зүйн нэгдмэл орчин бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт хуулийн төслийн үндсэн зорилгыг хангах эсэхийг үнэлэн тогтооно.

Хуулийн төсөлд “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн зорилго нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино” гэж заасан байна.

Хуулийн төслийг анхдагч хуулийн төрлөөр боловсруулсан тул төслийн зорилгыг тогтоохдоо хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох бусад материалыг судлах замаар дараах байдлаар тоймлов. Өөрөөр хэлбэл, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг дараах гол зорилго тавьж боловсруулжээ. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг тодорхой болгох;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах;
3. Төслийн бэлтгэл үе шатны үндсэн асуудал болох техник, эдийн засгийн үндэслэлд хамаарах зохицуулалт бий болгох;
4. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлснээр нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах;

5. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн үр өгөөжийг тооцох.

Аргачлалд заасны дагуу хуулийн төсөлд дээрх зорилгод хүрэх чиглэлээр тусгагдсан зүйл, хэсэг, заалтыг сонгон зорилгод хүрэх байдлыг үнэлэх юм.

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт

№	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилго	Зорилгыг хангахад чиглэсэн хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт																										
1	Зорилго-1: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг тодорхой болгох;	7 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл 7.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд үндэслэн дараах байдлаар ангилна: <table><tr><th>№</th><th>Төслийн ангилал</th><th>Төсөвт өртөг /төгрөг/</th><th>Хэрэгжих хугацаа /жил/</th></tr><tr><td>1.</td><td>I түвшин буюу жижиг</td><td>5 тэрбум хүртэл</td><td>Хоёр хүртэл</td></tr><tr><td>2.</td><td>II түвшин буюу дунд</td><td>5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл</td><td>Гурав хүртэл</td></tr><tr><td>3.</td><td>III түвшин буюу том</td><td>20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл</td><td>Дөрөв хүртэл</td></tr><tr><td>4.</td><td>IV түвшин буюу хөгжлийн</td><td>100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл</td><td>Тав хүртэл</td></tr><tr><td>5.</td><td>V түвшин буюу мега</td><td>350 тэрбумаас дээш</td><td>Таваас дээш</td></tr></table> 7.4.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл нь дараах төрөлтэй байна: 7.4.1.боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг хүний хөгжлийг дэмжих, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн нийгмийн салбарын төсөл; 7.4.2.эрчим хүч, зам тээвэр, усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн шугам сүлжээ, шинжлэх ухаан, цахим хөгжил, инноваци, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон хүнд аж үйлдвэр зэрэг эдийн засгийн салбарын төсөл; 7.4.3.үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, онцгой байдал, гадаад бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий аюулгүй байдал, гадаад бодлогын салбарын төсөл; 7.4.4.шүүх засаглал, хууль зүй, дотоод хэрэг, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэсэн төрийн захиргааны салбарын төсөл.			№	Төслийн ангилал	Төсөвт өртөг /төгрөг/	Хэрэгжих хугацаа /жил/	1.	I түвшин буюу жижиг	5 тэрбум хүртэл	Хоёр хүртэл	2.	II түвшин буюу дунд	5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл	Гурав хүртэл	3.	III түвшин буюу том	20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл	Дөрөв хүртэл	4.	IV түвшин буюу хөгжлийн	100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл	Тав хүртэл	5.	V түвшин буюу мега	350 тэрбумаас дээш	Таваас дээш
№	Төслийн ангилал	Төсөвт өртөг /төгрөг/	Хэрэгжих хугацаа /жил/																									
1.	I түвшин буюу жижиг	5 тэрбум хүртэл	Хоёр хүртэл																									
2.	II түвшин буюу дунд	5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл	Гурав хүртэл																									
3.	III түвшин буюу том	20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл	Дөрөв хүртэл																									
4.	IV түвшин буюу хөгжлийн	100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл	Тав хүртэл																									
5.	V түвшин буюу мега	350 тэрбумаас дээш	Таваас дээш																									

2	Зорилго-2: Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах;	18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт 18.1.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт хамаарна. 18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ: 18.2.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангах, тогтвортой хөгжилд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, төрийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл; 18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл; 18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл; 18.2.4.гадаадын зээлийн санхүүжилтээр хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны бодлого, зорилготой уялдсан, эдийн засгийн үр ашиг, өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нарийн төвөгтэй техник технологи шаардсан, урт хугацаанд үр өгөөжөө хадгалах, дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл; 18.2.5.гадаадын тусламжийн санхүүжилтээр энэ хуулийн 18.2.4-т зааснаас гадна хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түншээс Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан салбар, зориулалт хязгаарлахгүй, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулж, хүний хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсвийн хөрөнгө оруулалтын бүх ангиллын төсөл; 18.2.6.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зорилго, нөхцөл бүхий төсвийн хөрөнгө оруулалтын III – V ангиллын төсөл.
3	Зорилго-3: Төслийн бэлтгэл үе шатны үндсэн асуудал болох техник, эдийн	21 дүгээр зүйл.Техник, эдийн засгийн үндэслэл 21.1.Энэ хуулийн 7.1-д заасан төсвийн хөрөнгө оруулалтын IV, V ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

	засгийн үндэслэлд хамаарах зохицуулалт бий болгох;	21.2.Шинэ техник технологи, инноваци нэвтрүүлэх энэ хуулийн 7.1-д заасан I, II болон III ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай эсэхийг төслийн онцлог, цар хүрээнээс хамаарч, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ. 21.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардлын дээд хэмжээг төсөвт өртгийн 3 хувьд багтаан тогтооно. 21.4.Техник, эдийн засгийн үндэслэлээр эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нь тогтоогдсон төслийг эрэмбэлж, түүний дагуу зураг төслийг боловсруулна.
4	Зорилго-4: Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлснээр нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах;	35 дугаар зүйл.Мэдээллийн сан, ил тод, нээлттэй байдал 35.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт, тайлагналттай холбоотой мэдээллийг нэгтгэн бүртгэх, шинжилж боловсруулах, ил тод, хүртээмжтэй байдлаар ашиглах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн санг ажиллуулна. 35.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, цахим системээр мэдээллийг ил тод, нээлттэй байх нөхцөлийг хариуцан ажиллана. 37 дугаар зүйл.Цахим системийн удирдлага, зохион байгуулалт 37.1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 37.1.1.их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухаанд тулгуурлан төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төслийг үнэлэх, эрэмбэлэх; 37.1.2.төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах; 37.1.3.өмчид бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах; 37.1.4.мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх. 37.2.Цахим системийн удирдлага, зохион байгуулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.
5	Зорилго-5: Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн үр	42 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн үр өгөөж 42.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр дүн, хөрөнгийн ашиглалт, түүний үр

	өгөөжийг тооцох.	өгөөжийг энэ хуулийн 11.1.6-д заасан аргачлалын дагуу тооцож, үнэлэх бөгөөд үнэлгээний тайланг цахим системд тайлагнана. 42.3.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 42.1-д заасан үнэлгээг дотоод болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын байгууллага, шинжээч оролцуулан зохион байгуулж болно.
--	------------------	---

3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт

Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгчид хуулийг дагаж мөрдөх боломжтой эсэх болон хэрэгжүүлэх боломжтой юу гэсэн асуултад хариу өгөх нь уг шалгуур үзүүлэлтийн зорилго юм. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх байгууллага, хуулийн этгээд нь тодорхой эсэх, тодорхой бол тэдгээр этгээдэд зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо бодит байдалд байгаа эсэхийг урьдчилан тандах замаар таамаглах шаардлагын үүднээс уг шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Хүснэгт 2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт

8 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цаглавар 8.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын төлөвлөлтийн үе шатанд дараах цаглаварыг мөрдөнө: 8.2.1.сум, дүүрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн саналыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор авах; 8.2.2.сум, дүүргийн Засаг дарга иргэдийн саналыг харгалзан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.1-д заасны дагуу үнэлгээ хийж, жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх; 8.2.3.аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.2-т заасны дагуу үнэлж, эрэмбэлэн, шаардлага хангасан төслийг жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.	15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх 15.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.1.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.2-т заасны дагуу үнэлж, эрэмбэлэн тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; 15.1.2.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, түүний гүйцэтгэлийн талаарх тайлан мэдээллийг нэгтгэх, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг хариуцах; 15.1.3.эрх шилжүүлсэн төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн
---	--

удирдлага, ашиглалтыг зохион байгуулах;

15.1.4.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтад энэ хуульд заасан зарчим, нийтлэг шаардлага болон журам, аргачлалыг мөрдөх;

15.1.5.төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн нэгдсэн санг төлөвлөлтийн шатанд бүрдүүлэх, тайлагнах, дүгнэх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх.

15.1.6.энэ хуулийн 13.1.2 – 13.1.10-д заасан бүрэн эрх.

15.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж ажиллах бөгөөд томилох эрх бүхий этгээд нь нэгжийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

16 дугаар зүйл.Захиалагчийн чиг үүрэг

16.3.Захиалагч энэ хуулийн 16.2.4, 16.2.5-д заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас тухайн төслийн хэрэгжих хугацаа болон төсөвт өртгийг нэмэгдүүлсэнтэй холбоотой төсөвт учруулсан хохирлыг бүрэн хариуцна.

18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт

18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ:

18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

34 дүгээр зүйл.Тайлагналт, үр дүн

34.8.Захиалагч нь захиалагчийн техник, технологийн хяналт хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг, төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын зардлаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг тус тус дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнана.

43 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан

43.1.Барилга, авто зам, төмөр зам болон эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарын технологийн хөгжлийг дэмжих, норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилго бүхий төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сантай байна.

47 дугаар зүйл.Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

47.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэгчийг нийт гүйцэтгэсэн төслийн гүйцэтгэл, үр дүнд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтээр жил тутамд үнэлнэ:

47.1.1.төслийн чанар, стандартын болон аюулгүйн шаардлага хангасан байдал;
47.1.2.төслийн хэрэгжүүлсэн хугацаа;
47.1.3.төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэгжүүлсэн байдал;
47.1.4.төслийн үр өгөөж, ашиглагч болон олон нийтийн үнэлгээ;
47.1.5.ногоон технологи хэрэглэсэн байдал, байгаль орчин болон хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан үнэлгээнд үндэслэн гүйцэтгэгчийг дараах жагсаалтад хамруулна:

47.2.1.сайн гүйцэтгэлтэй буюу “ногоон”;
47.2.2.дундаж гүйцэтгэлтэй буюу “шар”;
47.2.3.хангалтгүй гүйцэтгэлтэй буюу “улаан”.

47.4.Төслийн гүйцэтгэгчийг дараах байдлаар урамшуулна:

47.4.1.худалдан авах ажиллагаанд ижил үнэлгээтэй хэд хэдэн тендер байх тохиолдолд энэ хуулийн 47.2-т заасан гүйцэтгэгчийн жагсаалтын дагуу эрэмбэлнэ;

47.4.2.гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр олгоход “ногоон” жагсаалтын гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардахгүй, “шар” жагсаалтын гүйцэтгэгч төлбөрийн 50 хувьтай тэнцэх дүнгийн баталгаа ирүүлнэ.

47.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 47.1-д заасан үнэлгээнд үндэслэн “улаан” жагсаалтын гүйцэтгэгчийн төрийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг гурван жилийн хугацаагаар хязгаарлаж болно.

3.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, хэсэг, заалт

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг үнэлнэ. Хуулийн төслийн дараах зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Хүснэгт 3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх
хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.18.“техник, технологийн хяналт” гэж төсөл батлагдсан зураг төсөл, төсөв, холбогдох норм, норматив, техникийн баримт бичиг болон гэрээнд заасны дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.12.“зураг төсөл зохиогч” гэж захиалагчтай зураг төсөл боловсруулах гэрээ байгуулсан эрх бүхий хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.19.“техник, эдийн засгийн үндэслэл” гэж төслийг хэрэгжүүлэх боломж, технологийн шийдэл, байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж тооцсон, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглагдах иж бүрэн судалгаа, дүн шинжилгээнд суурилсан баримт бичгийг;

5 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчим

5.1.2.төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээнд үндэслэсэн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн өгөөжтэй байх буюу үр ашигтай байх зарчим;

9 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйл

9.6.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эрх бүхий этгээдээс нэмэлт санхүүжилтийг энэ хуульд зааснаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төсвөөс нэмэлт эх үүсвэр, санхүүжилтийг төлөвлөх, санхүүжүүлэхийг хориглоно.

13 дугаар зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх

13.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.төсвийн хөрөнгө оруулалтын шилжих болон шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.3-т заасны дагуу үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх

14.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн өргөн мэдүүлснээр хэлэлцэж, энэ хуульд заасан зарчим, төсөлд тавигдах нийтлэг шаардлага, төслийн ангилал, зориулалтыг баримтлан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн батлах;

18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт

18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ:

18.2.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангах, тогтвортой хөгжилд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, төрийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.4.гадаадын зээлийн санхүүжилтээр хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны бодлого, зорилготой уялдсан, эдийн засгийн үр ашиг, өсөлтийг

дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нарийн төвөгтэй техник технологи шаардсан, нийгмийн ач холбогдолтой, урт хугацаанд үр өгөөжөө хадгалах, дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.5.гадаадын тусламжийн санхүүжилтээр энэ хуулийн 18.2.4-т зааснаас гадна хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түншээс Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан салбар, зориулалт хязгаарлахгүй, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулж, хүний хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсвийн хөрөнгө оруулалтын бүх ангиллын төсөл;

18.2.6.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зорилго, нөхцөл бүхий төсвийн хөрөнгө оруулалтын III – V ангиллын төсөл.

21 дүгээр зүйл.Техник, эдийн засгийн үндэслэл

21.2.Шинэ техник технологи, инноваци нэвтрүүлэх энэ хуулийн 7.1-д заасан I, II болон III ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай эсэхийг төслийн онцлог, цар хүрээнээс хамаарч, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

29 дүгээр зүйл.Төслийн гэрээний удирдлага

29.4.Төсөл хэрэгжүүлэх гэрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.3-т зааснаас гадна дараах нөхцөлийг тусгана:

29.4.3.гэрээний нийт үнийн дүнг батлагдсан төсвийн дагуу зардлын нэр төрөл бүрээр буюу барилга угсралт, төсөл хэрэгжүүлэхэд тавих хяналт, магадалшгүй ажил, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болон зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг зөвлөх үйлчилгээний зардал /нэг бүрчлэн/;

Тайлбар:“Магадалшгүй ажил” гэдэгт зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдаагүй бөгөөд ажлын явцад бий болох нэмэлт, өөрчлөлт, зайлшгүй шаардлагатай ажлын зардлыг ойлгоно.

33 дугаар зүйл.Төсөвт өртгийн өөрчлөлт

33.6.Захиалагч, захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь энэ хуульд заасныг зөрчиж төсөвт өртгийг нэмэгдүүлэх аливаа шийдвэр гаргасан, эсхүл төсөвт өртгийг нэмэгдүүлэх тухай гаргасан хүсэлт нь энэ хуулийн 33.4-т заасан дүгнэлтээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд захиалагчийн техникийн хяналтын болон зохиогчийн хяналтын зардлыг холбогдох төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт буцаан төвлөрүүлнэ.

41 дүгээр зүйл.Хөрөнгийн ашиглалт, сайжруулалт

41.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын дүнд бий болсон хөрөнгийг ашиглалтад оруулах үед цахим систем дээр хөрөнгийн бүртгэлтэй уялдуулан кодлох бөгөөд энэхүү бүртгэлээр тухайн хөрөнгийн шаардлагатай засвар, сайжруулалтын хуваарь, хугацааг урьдчилан тодорхойлдог байна.

47 дугаар зүйл.Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

47.6.“Улаан” жагсаалтын гүйцэтгэгч болон түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан “улаан” жагсаалтад байх хугацаандаа шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр, эсхүл бусад хуулийн этгээдээр дамжуулан төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлд оролцохыг хориглоно.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зохицуулалт

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр тогтооно. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг стандарт асуултуудад хариулах замаар үнэлдэг. Иймд, хуулийн төслийн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг бус төслийг бүхэлд нь үнэлнэ.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан үнэлнэ. Тодруулбал, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслөөс сонгосон зүйл, хэсэг, заалтын үр нөлөөг дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлэх болно.

Хүснэгт 4.Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт, шалгах хэрэгсэл

№	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг үнэлэх
3	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
4	Харилцан уялдаа	Харилцан уялдаатай эсэхийг шалгах

4.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

- **Зорилго 1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг тодорхой болгох**

7 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл

7.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд үндэслэн дараах байдлаар ангилна:

№	Төслийн ангилал	Төсөвт өртөг /төгрөг/	Хэрэгжих хугацаа /жил/
1.	I түвшин буюу жижиг	5 тэрбум хүртэл	Хоёр хүртэл
2.	II түвшин буюу дунд	5 тэрбумаас дээш 20 тэрбум хүртэл	Гурав хүртэл
3.	III түвшин буюу том	20 тэрбумаас дээш 100 тэрбум хүртэл	Дөрөв хүртэл
4.	IV түвшин буюу хөгжлийн	100 тэрбумаас дээш 350 тэрбум хүртэл	Тав хүртэл
5.	V түвшин буюу мега	350 тэрбумаас дээш	Таваас дээш

7.4.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл нь дараах төрөлтэй байна:

7.4.1.боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг хүний хөгжлийг дэмжих, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн нийгмийн салбарын төсөл;

7.4.2.эрчим хүч, зам тээвэр, усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн шугам сүлжээ, шинжлэх ухаан, цахим хөгжил, инноваци, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн болон хүнд аж үйлдвэр зэрэг эдийн засгийн салбарын төсөл;

7.4.3.үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, онцгой байдал, гадаад бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүхий аюулгүй байдал, гадаад бодлогын салбарын төсөл;

7.4.4. шүүх засаглал, хууль зүй, дотоод хэрэг, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангахад чиглэсэн төрийн захиргааны салбарын төсөл.

Үнэлгээ:

Олон улсын валютын сангийн 2023 онд хийсэн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын шинэчлэл” тайланд “... мега төсөлд ямар төсөл хамаарах, төслийн төрөл, ангилал тодорхой бус байна ...” гэж, Дэлхийн банкны 2025 онд хийсэн “Монгол Улсын төрийн санхүүгийн үнэлгээ”-нд “... Монгол Улсын нийтэд чиглэсэн хөрөнгө оруулалт нь хэд хэдэн эх үүсвэрээс санхүүждэг боловч эдгээрийг хөрөнгө оруулалтаар нь ангилан эрэмбэлэх тодорхой тогтолцоо байхгүй ...” гэж дүгнэсэн байдаг.²

Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдээр төсвийн хөрөнгө оруулалтад тулгамдсан асуудлын нэг нь төлөвлөлт хангалтгүй байдал хэмээн үзсэн. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг хуульд тодорхойлоогүйтэй холбоотой хэмээн Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан /цаашид “Тандан судалгаа” гэх/-д дурджээ.

Тандан судалгааны тайланд “... Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 сая төгрөгийн, 80 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрт нэгэн ижил хууль зүйн зохицуулалт үйлчилж байна. Олон улсад төслийг төсөвт өртөг, төслийн эрсдэл, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын салбар зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн ангилдаг бөгөөд төслийн ангилал бүрд төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын тохирсон, оновчтой зохицуулалт үйлчилж байна. Монгол Улсад улсын төсвийн хөрөнгөөр ямар ангиллын төсөл хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ямар ангиллын төсөл хэрэгжүүлэх зэрэг санхүүгийн эх үүсвэртэй уялдсан бодлогоо тодорхой болгосон нөхцөлд төр, орон нутгийн чиг үүргийн хуваарилалт оновчтой болж, төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нэмэгдэнэ ...” гэж тусгасан байна.³

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд төсөвт өртөг болон хэрэгжих хугацаа гэсэн хоёр үзүүлэлтэд үндэслэн төсвийн хөрөнгө оруулалтын төслийг I түвшин буюу жижиг, II түвшин буюу дунд, III түвшин буюу том, IV түвшин буюу хөгжлийн, V түвшин буюу мега хэмээн тав ангилжээ.

2025 онд улсын төсөвт батлагдсан төслийн төсөвт өртөг 165.0 сая төгрөгөөс 324 тэрбум төгрөг хүртэл, харин гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн төсөвт өртөг 23 тэрбум төгрөгөөс 5.8 их наяд төгрөг хүртэл байна.

² Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 111 дүгээр тал

³ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 118 дугаар тал

Хүснэгт 5.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төсөвт өртгийн судалгаа⁴

Эх үүсвэр	Он	Төсөвт өртөг (төгрөг)					Нийт
		5 тэрбум хүртэл	20 тэрбум хүртэл	100 тэрбум хүртэл	350 тэрбум хүртэл	350 тэрбумаас дээш	
Улсын төсөв	2026	283	193	83	19	1	579
	2025	299	223	75	16		613
	2024	886	341	77	13	2	1319
	2023	844	238	48	13		1143
	2022	1104	220	42	10		1376
	2021	931	145	24	6		1106
	2020	1183	129	38	6		1356
Гадаад зээл, тусламж	2026	0	18	43	38	14	113
	2025	0	12	32	37	17	98

Сангийн яамны дээрх судалгаанаас үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн 50 – 88 хувь нь I түвшин буюу жижиг, 9 – 36 хувь нь II түвшин буюу дунд, 2 – 14 хувь нь III түвшин буюу том, 0.4 – 3 хувь нь IV түвшин буюу хөгжлийн, 0.2 хувь нь V түвшин буюу мега төсөлд хамаарна. Харин гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн 12 - 16 хувь нь II түвшин буюу дунд, 33 – 38 хувь нь III түвшин буюу том, мөн 33 – 38 хувь нь IV ангиллын буюу хөгжлийн, 12 – 17 хувь нь V ангиллын буюу мега төсөлд хамаарч байна.

Төслийн хэрэгжих хугацааг төслийн ангилалтай уялдуулан хоёр хүртэл жилээс эхлэн нэг жилээр нэмэгдүүлэн хуулийн төсөлд тусгасан байх бөгөөд V түвшин буюу мега төслийн хэрэгжих хугацааг таваас дээш жил хэмээн заажээ.

Төслийн ангиллыг тогтооход төсөвт өртөг болон хэрэгжих хугацааны алийг суурь үзүүлэлт болгох талаар хуулийн төслийн 7.2-т төсөвт өртгийг суурь болгохоор тусгасан байна. Ингэснээр 300 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй боловч 6 жилийн хугацаанд хэрэгжих төсөл нь IV түвшин буюу хөгжлийн төсөл үү, эсхүл V түвшин буюу мега төсөл үү гэх асуудал шийдвэрлэгджээ. Өөрөөр хэлбэл, энэ нөхцөлд төслийн төсөвт өртгийг суурь болгох буюу 300 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 жилийн хугацаанд хэрэгжих төсөл нь IV түвшин буюу хөгжлийн төсөлд хамаарна.

Сангийн яамны судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслийн хэрэгжих дундаж хугацаа 1.8 – 4.7 жил бөгөөд нэг төслийн хэрэгжих хугацаа дунджаар 0.9 жилээр, гурван төсөл тутмын нэг төслийн хэрэгжих хугацаа хойшилдог байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 7.3-т V ангиллын төслийн хэрэгжих хугацааг төслийн онцлог, төслийн байршлаас хамааран 5 хүртэлх жил байж болно хэмээн заасан. Энэ нь V түвшний буюу мега төсөл бүр 5-аас дээш жилийн хугацаанд хэрэгжихээр хязгаарлалт тогтоосон мэт нөхцөлийг арилгасан байна.

Хуулийн төслийн 7.4-т төсвийн хөрөнгө оруулалтын төслийн нийгмийн салбарын, эдийн засгийн салбарын, аюулгүй байдал, гадаад бодлогын салбарын

⁴ Сангийн яамны 2025 оны судалгаа

болон төрийн захиргааны салбарын гэсэн төслийн 4 төрлийг тодорхойлжээ. Хуулийн төсөлд тодорхойлсон төслийн 4 төрөлд нийгмийн харилцааны бүхий л салбар, хүрээ багтсан байх бөгөөд ялангуяа төрөөс иргэдэд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээ багтсан болно. Нөгөөтээгүүр, төслийн төрлийг жагсаалтаар бус төслийн шинж, онцлог, зориулалт, хамрах хүрээ зэрэгт үндэслэн агуулгаар нь тодорхойлсон нь оновчтой болжээ. Тодруулбал, цаашид шинээр хэрэгжих төслийг шинж, онцлог, салбар, хамрах хүрээ зэрэгт үндэслэн аль нэг төрөлд хамруулах боломжтой юм.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн 5 ангилал болон төслийн 4 төрлийг ойлгомжтой, тодорхой тусгасан буюу зорилго 1 хангагдсан гэж үзлээ.

➤ **Зорилго 2.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах**

18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт

18.1.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт хамаарна.

18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ:

18.2.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангах, тогтвортой хөгжилд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, төрийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.4.гадаадын зээлийн санхүүжилтээр хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны бодлого, зорилготой уялдсан, эдийн засгийн үр ашиг, өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нарийн төвөгтэй техник технологи шаардсан, урт хугацаанд үр өгөөжөө хадгалах, дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.5.гадаадын тусламжийн санхүүжилтээр энэ хуулийн 18.2.4-т зааснаас гадна хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түншээс Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан салбар, зориулалт хязгаарлахгүй, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулж, хүний хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсвийн хөрөнгө оруулалтын бүх ангиллын төсөл;

18.2.6.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зорилго, нөхцөл бүхий төсвийн хөрөнгө оруулалтын III – V ангиллын төсөл.

Үнэлгээ:

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”-д “... Аливаа төслийг урьдчилан сайтар судалсны үндсэн дээр түүнийг ямар эх үүсвэрээс, ямар арга замаар санхүүжүүлэх нь хамгийн оновчтой болохыг тодорхойлдог. Бүхий л төслийг улсын төсвөөс, гадаад зээлээр санхүүжүүлнэ гэж төлөвлөх нь оновчтой бус бөгөөд зарим томоохон мега төсөлд төсвийн болон гадаад зээллэгийн санхүүжилт ашиглахаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг оролцуулсан холимог санхүүжилтийн аргыг (Blended finance) хэрэглэх нь оновчтой байдгийг анхаарах ...” гэж дүгнэсэн.⁵

Олон улсын валютын сангийн 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл - техникийн туслалцааны тайлан”-д⁶ “... Төрийн өмчит томоохон компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг Эдийн засаг, хөгжлийн яам болон Сангийн яамаар хянуулж, хэлэлцүүлэх журам тогтоож, төрийн өмчит компанийн удирдлага, хяналтыг сайжруулах. Төрийн өмчит компанийн санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг олон нийтэд нээлттэй, ил тод нийтлэх” гэж, “... Бүх томоохон төсөл сахилга баттай байхын тулд тэдгээр нь санхүүжилтийн бүх эх үүсвэр (дотоод, гадаад, төр, хувийн хэвшлийн түншлэл)-ээр хэрэгжих байсан ч улсын бүх хөрөнгө оруулалтад хамаарна ...” гэж тус тус дурджээ.

Тандан судалгааны тайланд төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон байх бөгөөд “... Төсвийн хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрийн зориулалт, ангилал тодорхой бус байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хөгжлийн сан, хувийн хэвшил болон санхүүгийн бусад эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа ч эдгээр төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Үүнээс болж төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд давхардах, хэрэгцээгүй болох, эсхүл бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байх зэрэг сөрөг тал гарч байна ...” гэжээ.⁷

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “... Төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг хамруулсан санхүүжилтийн оновчтой хуваарилалт, зориулалт, хамрах хүрээг тогтоогоогүйн улмаас хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийг бууруулах, хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилт бүрэн хангагдахгүй байх, хувийн хэвшил, орон нутаг, Засгийн газрын хэрэгжүүлэх төслүүд давхардах зэрэг асуудал, зөрчлүүд гарч байна,” гэж практикт тулгамдсан асуудлыг тодорхойлсон.

⁵ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”, Улсын Их Хурлын цахим хуудас, <https://www.parliament.mn/nr/62969/>

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 111 дүгээр тал

⁷ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 120 дугаар тал

Хуулийн төслийн 18.1-д төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт хамаарна хэмээн заажээ. Тодруулбал, төсвийн хөрөнгө оруулалт нь 6 эх үүсвэрээр бүрдэхээр байна.

Хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хөгжлийн сан, Үндэсний баялгийн сан, Засгийн газрын тусгай сан зэрэг эх үүсвэрийн талаар тусгаагүй боловч эдгээр эх үүсвэрээр төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг Компанийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрмээр зохицуулдаг болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд тусгаагүй санхүүгийн бусад эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхэд баримтлах, дагаж мөрдөх хууль тогтоомж байна.

Хуулийн төслийн 18.2-т төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн зорилго, зориулалтыг дараах байдлаар тусгажээ:

- 18.2.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангах, тогтвортой хөгжилд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, төрийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;
- 18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;
- 18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;
- 18.2.4.гадаадын зээлийн санхүүжилтээр хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны бодлого, зорилготой уялдсан, эдийн засгийн үр ашиг, өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нарийн төвөгтэй техник технологи шаардсан, урт хугацаанд үр өгөөжөө хадгалах, дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;
- 18.2.5.гадаадын тусламжийн санхүүжилтээр энэ хуулийн 18.2.4-т зааснаас гадна хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түншээс Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан салбар, зориулалт хязгаарлахгүй, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулж, хүний хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсвийн хөрөнгө оруулалтын бүх ангиллын төсөл;
- 18.2.6.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зорилго, нөхцөл бүхий төсвийн хөрөнгө оруулалтын III – V ангиллын төсөл.

Хүснэгт 6.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн санал (төслийн ангиллаар)

Эх үүсвэр	Төслийн ангилал				
	I түвшин буюу жижиг	II түвшин буюу дунд	III түвшин буюу том	IV түвшин буюу хөгжлийн	V түвшин буюу мега
Улсын төсөв					
Орон нутгийн төсөв					
Орон нутгийн хөгжлийн сан					
Гадаадын зээл					
Гадаадын тусламж					
Төр, хувийн хэвшлийн түншлэл					

Дээрх хүснэгтээс харахад I, II түвшний төслийг орон нутгийн төсвөөр, III, IV болон V түвшний төслийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхийг илүүтэй зорьсон байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн зориулалтыг уян хатан тусгасан хэмээн үзэж болно.

Харин, төрийн суурь үйлчилгээ, нийгмийн суурь үйлчилгээ, ногоон орчин, ногоон байгууламж, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, нийгэм, эдийн засгийн үр өгөөж, эдийн засгийн үр ашиг, үр өгөөж гэсэн нэр томъёог ялгаатай агуулгаар ойлгох уу, эсхүл нэгэн адил агуулгаар ойлгох уу гэдгийг жигдлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 18.2.4-т “дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II - V ангиллын төсөл” гэжээ. Энэ нь хуулийн төслийн 7.4-т тодорхойлсон төслийн аль төрөлд хамаарах нь ойлгомжгүй байх тул “дэд бүтцийн буюу” гэдгийг хасахыг зөвлөнө.

Дүгнэлт: Хуулийн төслийн 18.1-д төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрэн хамруулахыг зорьсон байх ба 18.2-т эдгээр эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн зорилго, зориулалтыг уян хатан тусгасан буюу зорилго 2 хангагдсан хэмээн үзлээ.

➤ **Зорилго 3.Төслийн бэлтгэл үе шатны үндсэн асуудал болох техник, эдийн засгийн үндэслэлд хамаарах зохицуулалт бий болгох**

21 дүгээр зүйл.Техник, эдийн засгийн үндэслэл

21.1.Энэ хуулийн 7.1-д заасан төсвийн хөрөнгө оруулалтын IV, V ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.

21.2.Шинэ техник технологи, инновац нэвтрүүлэх энэ хуулийн 7.1-д заасан I, II болон III ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай эсэхийг төслийн онцлог, цар хүрээнээс хамаарч, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

21.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардлын дээд хэмжээг төсөвт өртгийн 3 хувьд багтаан тогтооно.

21.4.Техник, эдийн засгийн үндэслэлээр эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нь тогтоогдсон төслийг эрэмбэлж, түүний дагуу зураг төслийг боловсруулна.

Үнэлгээ:

Үндэсний аудитын газрын 2023, 2024 оны тайланд “... ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох ...” хэмээн дүгнэсэн.⁸ Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас техник, эдийн засгийн үндэслэлийн талаар нийтлэг стандарт тогтоохыг зөвлөсөн.⁹

Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдээр төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа асуудлын нэг нь зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн боловсруулалт хангалтгүй хэмээн үзсэн.

Тандан судалгааны тайланд “... ТЭЗҮ, зураг төсөл, төсөв зэрэг ойлголтыг нэг мөр ойлгож хэрэглэхгүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл амжилттай хэрэгжих эсэх нь төслийн төлөвлөлтийн үе шатнаас, тодруулбал төслийн бэлтгэл үе шатнаас ихээхэн хамаардаг. Харин төслийн бэлтгэл үе шат нь ТЭЗҮ, зураг төсөл, төсөв, магадлал зохих ёсоор хийгдсэн эсэхээс хамаарна.

Техник, эдийн засгийн үндэслэл гэдэг ойлголтыг Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд тусгасан боловч нэр томъёоны тайлбар хийгээгүй байна. Нэр томъёоны ойлгомжгүй, тодорхой бус байдлаас шалтгаалан ТЭЗҮ нь ямар агуулга, бүтэцтэй байх, зураг төсөл нь ТЭЗҮ-ээс хэрхэн ялгагдах, төсвийг хэрхэн тооцох зэрэг асуудал шийдэлгүй хэвээр байна. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүх төсөлд ТЭЗҮ, зураг төсөл, төсөв шаарддаг нь төсөвт тусгагдахгүй бол 2 жилийн дараа хэрэглэгдэхгүй болж үргүй зардал гарах, чанаргүй хийгдэх зэрэг сөрөг талтай болно ...” хэмээн дурдсан байна.¹⁰

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “... Хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл ажил буюу зураг төсөл, ТЭЗҮ зэрэг ойлголтууд зохицуулалтын хувьд бүрхэг, тодорхой бус учир бүх төсөлд ижил шаардлага тавигддаг, мөн төлөвлөж хэрэгжүүлэхэд төслийн хугацаа болон зардал нэмэгдэхэд нөлөөлж байна,” хэмээн үзжээ.

Хуулийн төслийн 4.1.20-д “техник, эдийн засгийн үндэслэл” гэж төслийг хэрэгжүүлэх боломж, технологийн шийдэл, байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж тооцсон, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглагдах иж бүрэн судалгаа, дүн шинжилгээнд суурилсан баримт бичгийг” хэлнэ хэмээн нэр томъёоны тодорхойлолт хийжээ. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтаар

⁸ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 106 дугаар тал

⁹ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 121 дүгээр тал

¹⁰ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 120, 121 дүгээр тал

хэрэгжүүлэх төсөлд мөрдөх, баримтлах техник, эдийн засгийн үндэслэлийн талаар нэгдсэн ойлголт өгөх ач холбогдолтой болжээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд техник, эдийн засгийн үндэслэлийн талаар тусгайлан зохицуулсан байна. Хуулийн төслийн 21.1, 21.2-т техник, эдийн засгийн үндэслэл заавал хийх болон хийж болох төслийн талаар заажээ. Тухайлбал; төсвийн хөрөнгө оруулалтын IV, V түвшний төсөлд техник, эдийн засгийн үндэслэл заавал хийнэ. Харин төсвийн хөрөнгө оруулалтын I, II болон III ангиллын төсөлд, гэхдээ эдгээр төсөл нь шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх төсөл бол техник, эдийн засгийн үндэслэл хийх эсэхийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардлын дээд хэмжээг төсөвт өртгийн 3 хувьд багтаан тогтоох бөгөөд зардлын дээд хэмжээг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран тогтооно гэж хуулийн төслийн 21.3-т тусгасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг хэт өндөр үнэ төлбөрөөр боловсруулдаг талаар олон нийтийн болон бусад байгууллагын санал, шүүмжлэлийг хүлээн авч дээд хэмжээ тогтоосон нь сайн талтай байна. Төслийн зураг төсөл, төсөв хараахан гараагүй нөхцөлд төсөвт өртгийг ямар төсвөөс тооцох нь тодорхой бус болох бөгөөд зардлын дээд хэмжээ 3 хувиас хэтрэхгүй байх, ингэхдээ тухайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардлын дээд хэмжээг бус зардлын хэмжээг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоохоор найруулах нь зүйтэй байна.

Техник, эдийн засгийн үндэслэлээр эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой нь тогтоогдсон төслийг эрэмбэлж, түүний дагуу зураг төслийг боловсруулахаар хуулийн төслийн 21.4-т заажээ. Энэ нь техник, эдийн засгийн үндэслэлийн өмнө зураг төсөл хийх үү, эсхүл дараа нь хийх үү, эсхүл техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан төсөлд зураг төсөл хийх шаардлагагүй гэх зэрэг асуудлыг нэг мөр болгон зохицуулжээ. Тодруулбал, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан төсөлд зураг төсөл заавал хийх бөгөөд ингэхдээ тухайн төсөл эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой нь тогтоогдсон байх шаардлагатай юм.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл үе шатны гол асуудал болох техник, эдийн засгийн үндэслэлд хамаарах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан буюу ямар төсөлд техник, эдийн засгийн үндэслэл заавал хийх, ямар төсөлд хийж болох болон зардлын дээд хэмжээ зэргийг тогтоосон буюу зорилго 3 хангагдсан хэмээн үзэж байна.

- **Зорилго 4.Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлснээр нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах**

35 дугаар зүйл.Мэдээллийн сан, ил тод, нээлттэй байдал

35.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт, тайлагналттай холбоотой мэдээллийг нэгтгэн бүртгэх, шинжилж боловсруулах, ил тод, хүртээмжтэй байдлаар ашиглах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн санг ажиллуулна.

35.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, цахим системээр мэдээллийг ил тод, нээлттэй байх нөхцөлийг хариуцан ажиллана.

37 дугаар зүйл.Цахим системийн удирдлага, зохион байгуулалт

37.1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

37.1.1.их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухаанд тулгуурлан төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төслийг үнэлэх, эрэмбэлэх;

37.1.2.төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах;

37.1.3.өмчид бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах;

37.1.4.мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх.

37.2.Цахим системийн удирдлага, зохион байгуулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Үнэлгээ:

Сангийн яам Азийн хөгжлийн банкт хамтран 2020 онд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг үе шаттай нэвтрүүлснээр санхүүжилтийн явцыг ил тод болгосон, санхүүжилтийг шууд гүйцэтгэгчийн дансанд шилжүүлдэг болсон, цаасны хэрэглээг 90 хувиар бууруулсан, 2023 онд анх удаа иргэдээс цахимаар санал авсан, захиалагчийн техник, технологийн хяналтыг цахим системд шилжүүлсэн, урьдчилсан үнэлгээг цахимаар хийдэг болсон, улсын төсөв, нийслэлийн төсвийн үйл ажиллагааг 100 хувь цахим болгосон, олон эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэсэн зэрэг ахиц дэвшил гарсан болно.

Цаашид төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд зохиогчийн хяналтыг шилжүүлэх, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг үргэлжлүүлэн ил тод, нээлттэй болгох, төсвийн хөрөнгө оруулалтыг нэг цонхоор төлөвлөх, хэрэгжүүлэх, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг үе шаттайгаар нэвтрүүлснээр хүний үйл ажиллагааг бууруулах, санхүү, нийгэм, эдийн засгийн шинжилгээг бүрэн цахимжуулж, сайжруулах технологийн шинэчлэл хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгүүдээр төсвийн хөрөнгө оруулалтад тулгамдаж байгаа нэг асуудлыг төлөвлөлт, хэрэгжилт, хяналт зэрэг үйл ажиллагааны мэдээлэл ил тод, нээлттэй бус, иргэд санал, гомдол гаргах боломжтой хязгаарлагдмал хэмээн үзжээ.¹¹

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд "... Төсвийн хөрөнгө оруулалтын үндэсний мэдээллийн сан бүрдүүлж, төсвийн хөрөнгө оруулалтад их өгөгдөл, хиймэл оюуныг нэвтрүүлснээр хэрэгцээ

¹¹ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 117 дугаар тал

шаардлагыг хангасан, хөгжлийг дэмжсэн оновчтой төслийг хэрэгжүүлнэ.” хэмээн хүрэх үр дүнг заажээ.

Хуулийн төслийн 35.1-д төслийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт тайлагналтын талаарх бүхий л мэдээллийг багтаасан төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн сан ажиллуулах, 35.3-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг мэдээллийн санг бүрдүүлэх, цахим системээр мэдээллийг ил тод, нээлттэй байх нөхцөлийг хариуцахаар тусгасан байна.

Хуулийн төслийн 37.1-д төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухаанд тулгуурлан төслийг төлөвлөх, үнэлэх, эрэмбэлэх /1/, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах /2/, өмчид бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах /3/, мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэх /4/ үйл ажиллагааг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр хэрэгжүүлэх, 37.2-т цахим системийн удирдлага, зохион байгуулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан байна. Түүнчлэн, хуулийн төслийн 5.1.7-д төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөл, хиймэл оюун ухаан, дижитал дэд бүтцэд тулгуурлан цахим системээр хэрэгжүүлэх буюу цахим удирдлагын зарчим баримтлах, 19.1.7-д төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах нийтлэг шаардлагын нэг нь их өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан цахим системд төлөвлөсөн байх гэж заажээ. Эдгээр зохицуулалт нь төсвийн хөрөнгө оруулалтад их өгөгдөл, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхэд чиглэсэн хэмээн үзнэ. Гэхдээ их өгөгдөл, хиймэл оюун ухаан нь хүний шийдвэр гаргалтад туслах, дэмжих, процессын ажиллагааг хялбаршуулах хэрэгсэл болохоос үндсэн суурь хэрэгсэл биш юм.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн нэгдсэн сан болон цахим систем аль алины удирдлага, зохион байгуулалтыг хариуцаж ажиллана. Хуулийн төслийн 35.3-т цахим системээр мэдээллийг ил тод, нээлттэй байлгах гэж, 37.2-т цахим системийн удирдлага, зохион байгуулалт гэж тусгасан нь цахим системийн талаар давхардуулан зохицуулсан гэж үзэхээр байна.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх болон төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах талаар хуулийн төсөлд тусгасан, улмаар мэдээллийн нээлттэй, ил тод байх зарчмыг бэхжүүлсэн буюу зорилго 4 хангагдсан хэмээн үзнэ.

➤ **Зорилго 5.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн үр өгөөжийг тооцох**

42 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн үр өгөөж

42.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр дүн, хөрөнгийн ашиглалт, түүний үр өгөөжийг энэ хуулийн 11.1.6-д заасан аргачлалын дагуу тооцож, үнэлэх бөгөөд үнэлгээний тайланг цахим системд тайлагнана.

42.3.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 42.1-д заасан үнэлгээг дотоод болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын байгууллага, шинжээч оролцуулан зохион байгуулж болно.

Үнэлгээ:

“Нээлттэй Нийгэм форум” төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаар 2022-2024 онд өгсөн санал, зөвлөмжид “... төслийн үр ашгийн мэдээллийг нийтэд ил болгох, судлаачид, олон нийтийн оролцоог зайлшгүй хангах ...”-ыг зөвлөсөн.¹²

Тандан судалгааны тайланд “... Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй байна. Энэ нь төслийн хэрэгжилт удаан, төсөвт өртөг нэмэгддэг зэрэгтэй шууд хамааралтай. Олон улсын валютын сангаас ижил түвшний улстай харьцуулахад Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр өгөөж хангалтгүй болохыг тэмдэглэсэн...”, “... төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч байгууллагын хариуцлага, хяналтын талаарх зохицуулалт хангалтгүйн улмаас өмчийн удирдлага сулрах, ашиглалтын үр өгөөжийг тооцохгүй байх, түүнчлэн чанаргүй барилга байгууламж баригдах зөрчлүүд их гарч байна;”, “... Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй байна,” хэмээн тусгажээ.¹³

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “... Улмаар төсөвт нэмэлт ачаалал үүсгэж, барилга байгууламж, дэд бүтэц хугацаандаа ашиглалтад ороогүйн улмаас боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж саарч, төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж буурах сөрөг үр дагаварт хүргэж байна ...” хэмээн практик шаардлагыг тодорхойлсон болно.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр дүн, хөрөнгийн үр өгөөжийг тооцдоггүй байдал практикт нийтлэг болсон. Төсвийн ерөнхийлөн захирагч эрхэлсэн салбартаа хэрэгжүүлсэн төслийн үр дүн болон хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг аргачлалын дагуу тооцож үнэлэх, уг үнэлгээний тайланг цахим системд тайлагнахаар хуулийн төслийн 42.1-д тусгажээ. Төслийн үр дүнгийн үнэлгээ болон хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн үнэлгээ нь ялгаатай эсэх, түүнчлэн ямар хугацаанд ямар давтамжтай уг үнэлгээг хийх нь хуулийн төсөлд тодорхой бус байна.

Хөрөнгийн үр өгөөжийг тооцоход тодорхой хэмжээний зардал гарна. Иймд, бүх ангилал, бүх төрлийн төслийн хөрөнгийн үр өгөөжийг тооцох уу, эсхүл тодорхой ангилал, төрөлд хамаарах төслийн хөрөнгийн үр өгөөжийг тооцох уу гэдгийг оновчтой тодорхойлох шаардлагатай.

Хуулийн төслийн 42.3-т хөрөнгийн үр өгөөжийг тооцох үнэлгээг дотоод болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын байгууллага, шинжээч оролцуулан зохион байгуулж болохоор заасан буюу мэргэжлийн этгээдийн оролцоог хангах зохицуулалт нь зөв болжээ. Гэхдээ, төсвийн хөрөнгө оруулалтын аль ч ангилал, төрлийн төсөл орон нутагт хэрэгжинэ. Иймд, төслийн үр дүн, хөрөнгийн ашиглалт, түүний үр өгөөжийг тооцож үнэлэхэд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга ямар оролцоотой байх талаар тусгавал илүү үр дүнтэй

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн үр өгөөжийг тооцох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан буюу зорилго 5 хангагдсан хэмээн үзлээ. Гэхдээ өмнө дурдсан буюу бүх ангилал, бүх төрлийн төсөлд хөрөнгийн

¹² Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 114 дүгээр тал

¹³ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 123 дугаар тал

үр өгөөжийг тооцох үнэлгээг хийх эсэх, ямар хугацаанд ямар давтамжтай хийх болон орон нутгийн оролцооны талаар судлан зохих засвар сайжруулалтыг хуулийн төсөлд тусгах нь үр нөлөөг нэмэгдүүлнэ.

4.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төсөлд практикт хэрэгжих боломжийг урьдчилан тогтоох шаардлагатай дараах агуулга бүхий зохицуулалт тусгагдсан тул өмнөх хэсэгт сонгон авсан.

➤ Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг

8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цаглавар

8.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын төлөвлөлтийн үе шатанд дараах цаглаврыг мөрдөнө:

8.2.1. сум, дүүрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн саналыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор авах;

8.2.2. сум, дүүргийн Засаг дарга иргэдийн саналыг харгалзан шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.1-д заасны дагуу үнэлгээ хийж, жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

8.2.3. аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.2-т заасны дагуу үнэлж, эрэмбэлэн, шаардлага хангасан төслийг жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 8.2-т заасан цаглаврын дагуу сум, дүүрэг эхлээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн саналыг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор буюу нэг сарын хугацаанд авах, дараа нь сум, дүүргийн Засаг дарга шинээр хэрэгжүүлэх төслийн саналд үнэлгээ хийж, жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч төсөлд үнэлгээ хийж, шаардлага хангасан төслийг жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төсвийн цаглаврыг мөрдөх буюу төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байх учиртай. Иймд, тухайн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн санал тухайн жилийн эхний хагаст багтаан бэлэн болсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сум, дүүрэгт шинээр хэрэгжүүлэх төсөлд иргэдийн саналыг авах нь иргэдийн оролцоог хангах нэг арга зам бөгөөд уг ажлыг сум, дүүрэг хариуцан зохион байгуулахаар тусгасан нь практикт хэрэгжих боломжтой. Харин иргэдийн саналыг ямар байдлаар авахаа сум, дүүрэг нутаг дэвсгэрийн онцлог, бусад хүчин зүйлийг харгалзан тогтоох боломжтой.

Хуулийн төслийн 8.2.1-д зааснаар иргэн албан ёсоор бүртгэлтэй оршин сууж буй нэгждээ саналаа өгнө. Сум, дүүрэг иргэдийн саналыг нэг сарын хугацаанд авахаар тогтоосон нь иргэдэд санал өгөх боломжийн хугацаа олгосон хэмээн үзнэ.

Сум, дүүргийн Засаг дарга иргэдийн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж, хуулийн төслийн 24.2.1-д заасан буюу төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийнэ. Иргэдийн саналыг авна гэдэг нь тухайн орон нутагт ямар төсөл илүү хэрэгцээтэй, шаардлагатай байгааг тодорхойлох зорилготой бөгөөд энэ нь сум, дүүргийн Засаг даргын хийх төслийн үнэлгээтэй холбогдоно. Сум, дүүргийн Засаг дарга хуулийн төслийн 24.2.1-д заасан үнэлгээг нэг сарын хугацаанд буюу 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хийж, дээд шатны буюу аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр тусгасан нь үнэлгээ хийхэд хүрэлцэхүйц хугацаа хэмээн үзнэ.

Хуулийн төслийн 8.2.3-т тусгаснаар аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийж, эрэмбэлэн, шаардлага хангасан төслийг жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга доод шатны буюу сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг үнэлж, нэгтгэн, шаардлага хангасан төслийн жагсаалт гаргахад хуанлийн 55 хоногийн хугацаа байна. Аймаг, нийслэлийн Засаг дарга төслийн ач холбогдлыг тухайн орон нутгийн хэмжээнд бус бүс нутгийн түвшинд үнэлж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан үнэлгээ хийнэ. Улмаар шаардлага хангасан төслийг салбараар нь гаргаж, тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шат орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох буюу иргэдийн саналыг авахаас эхлэх бөгөөд төлөвлөлтийн процессыг доороос дээш чиглэсэн байдлаар тусгасан нь оновчтой болжээ. Төслийн санал авах, төсөлд үнэлгээ хийх хугацаа нь хүрэлцэхүйц байна.

Түүнчлэн, Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалд сум, дүүрэг нь жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, аймаг, нийслэл нь жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсөлд үнэлгээ хийж, эрэмбэлэхээр заасан. Өөрөөр хэлбэл, сум, дүүрэг, аймаг, нийслэл нь дээрх хугацаанд шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийж, эрэмбэлэх ажиллагааг практикт хийж тогтсон байна.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд баримтлах цаглаврыг сум, дүүрэг, аймаг, нийслэл дагаж мөрдөж практикт нэгэнт тогтсон байх ба үүнээс өөр хугацааг хуулийн төсөлд заагаагүй байх тул хуулийн төслийн 8.2-т заасан цаглаврыг практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ. Харин хуулийн төслийн 8.2-т “улсын төсвийн хөрөнгө оруулалт” хэмээн тодруулан заасан тул төслийн 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан “улсын төслийн хөрөнгө оруулалтаар” гэсэн нь давхардаж байх тул хасах нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэг**

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх

15.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.2-т заасны дагуу үнэлж, эрэмбэлэн тухайн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

15.1.2. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, түүний гүйцэтгэлийн талаарх тайлан мэдээллийг нэгтгэх, төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг хариуцах;

15.1.3. эрх шилжүүлсэн төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг зохион байгуулах;

15.1.4. орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтад энэ хуульд заасан зарчим, нийтлэг шаардлага болон журам, аргачлалыг мөрдөх;

15.1.5. төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн нэгдсэн санг төлөвлөлтийн шатанд бүрдүүлэх, тайлагнах, дүгнэх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх.

15.1.6. энэ хуулийн 13.1.2 – 13.1.10-д заасан бүрэн эрх.

15.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж ажиллах бөгөөд томилох эрх бүхий этгээд нь нэгжийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 15.1-д аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрхийг дараах байдлаар тусгажээ:

- Хуулийн төслийн 15.1.1-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийж, эрэмбэлэн хүргүүлэхээр заасан. Энэ бүрэн эрх нь аймаг, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлдэг бүрэн эрх бөгөөд хэрэгжүүлэх ёстой бүрэн эрхийн нэг мөн болно. Харин хуулийн төсөлд "... төсөлд энэ хуулийн ...-д заасны дагуу үнэлж ..." гэж тусгасныг найруулгын хувьд сайжруулах шаардлагатай.
- Хуулийн төслийн 15.1.3-т эрх шилжүүлсэн төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг зохион байгуулах гэжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн төслийн төлөвлөлтөөс бусад үе шат буюу төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг зохион байгуулах нь зүй ёсны бөгөөд энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжтой юм.

- Хуулийн төслийн 15.1.4-т орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтад энэ хуульд заасан зарчим, нийтлэг шаардлага болон журам, аргачлалыг мөрдөх гэж заажээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслийн удирдлагад Засаг дарга ямар бүрэн эрх хэрэгжүүлэх болон ямар журам, аргачлалыг мөрдөх нь тодорхой бус байдаг. Хуулийн төсөлд дээрх заалтыг тусгаснаар 5 дугаар зүйлд заасан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчим, 19 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлага болон Засгийн газар, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журам, аргачлалыг мөрдөнө гэдэг нь тодорхой болж байна. Түүнчлэн, аймаг, нийслэлийн Засаг дарга эдгээр зарчим, нийтлэг шаардлага болон журам, аргачлалыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсвийн удирдлагын харилцаанд дагаж мөрдөхөд хүндрэл үүсэхгүй болно.
- Хуулийн төслийн 15.1.2, 15.1.5-д тайлан, мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгажээ. Эдгээр хэм хэмжээ нь давхардал үүсгэж болзошгүй тул нягталж, давхардлыг арилгах нь зүйтэй.
- Хуулийн төслийн 15.1.6-д төслийн 13.1.2 – 13.1.10 дахь бүрэн эрхийг эшлэн заажээ. Хуулийн төслийн 13.1.3-т төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалтыг бүрэн хариуцах гэж заасан бөгөөд энэ нь 15.1.3-т заасан бүрэн эрхтэй зарим талаар давхардал үүсгэж болзошгүй.

Түүнчлэн, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг хот, тосгонд шилжүүлсэн нөхцөлд аймаг, нийслэл /сум, дүүрэг/-ийн Засаг даргын бүрэн эрхийг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч хэрэгжүүлнэ. Одоогоор ийм шийдвэрийг эрх бүхий этгээд гаргаагүй болно. Иймд, хуулийн төслийн 15 дугаар зүйлийн гарчигт “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх” гэж оруулах практик шаардлага байхгүй.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцаанд аймаг, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхээс зарим бүрэн эрхийн давхардлыг нягталж, сайжруулсан нөхцөлд практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ. Тодруулбал, 15 дугаар зүйлийн гарчгаас “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэсэн хэсгийг хасах, төслийн 15.1.2, 15.1.5 дахь заалтыг нэгтгэн найруулахыг зөвлөж байна.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 15.3-т “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж ажиллах бөгөөд томилох эрх бүхий этгээд нь нэгжийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.” гэж тусгажээ.

Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд “Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс”

гэж¹⁴, 2024 оны 81 дүгээр тогтоолоор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд “Санхүү, хөрөнгө оруулалтын газар” гэж заасан¹⁵. Аймгуудад бүс, орон нутгийн хөрөнгө оруулалтын хэлтэс, нийслэлд хөрөнгө оруулалтын газар ажиллана. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь аймгуудад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжтэй, нийслэлд санхүүгийн нэгжтэй хамт нэг нэгж болон зохион байгуулагдсан байдаг.

Хуулийн төслийн 15.3-т аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж ажиллахаар заасан бөгөөд Засгийн газраас бүтэц, орон тооны хязгаарыг нэг бүрчлэн буюу нэг маягаар дээрх байдлаар тогтоож мөрдүүлдэг. Иймд, төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэлд шинээр байгуулах шаардлага үүсэхгүй болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрх бүхий этгээд нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.4-т заасны дагуу Засаг даргын Тамгын газрын дарга болно. Тамгын газрын дарга нь төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн удирдлагыг томилж, чөлөөлөхдөө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөхөөр хуулийн төслийн 15.3-т заасан.

Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан орон нутгийн албан хаагчдын сургалт, семинараар “... төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл хариуцсан нэг мэргэжилтэнтэй болох, албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалттай болох” санал нийтлэг гарч байсан.

Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн тайланд “... Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан албан хаагчдад шалгуур тавих, тэднийг сургаж мэргэшүүлэх,” арга хэмжээ авахыг зөвлөсөн байдаг.

Төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт төсөл хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх этгээд нь нэгжийн удирдлага тул түүнийг тогтвор, суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах нь төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй. Хэдийгээр нэгжийн удирдлагыг төрийн албанд томилох, чөлөөлөх нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр хийгдэх боловч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөх нь төрийн албанд тогтвортой ажиллах баталгааг хангах ач холбогдолтой.

Дүгнэлт: Хуулийн төслийн 15.3 дахь хэсгийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд ажилладаг бөгөөд тус нэгжийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх зохицуулалтыг практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

¹⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355780588761>

¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355674565491>

➤ **Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг**

16 дугаар зүйл.Захиалагчийн чиг үүрэг

16.3.Захиалагч энэ хуулийн 16.2.4, 16.2.5-д заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас тухайн төслийн хэрэгжих хугацаа болон төсөвт өртгийг нэмэгдүүлсэнтэй холбоотой төсөвт учруулсан хохирлыг бүрэн хариуцна.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 16.1-д төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төсвийн захирагч, эсхүл худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцаанд захиалагч байхаар заажээ. Өөрөөр хэлбэл, захиалагч нь төрийн байгууллага, түүнийг төлөөлөн эрх бүхий удирдах албан тушаалтан байна.

Хуулийн төслийн 16.2.4, 16.2.5-д төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийг хянах болон гүйцэтгэгч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, ажлын хуваарийг мөрдөөгүй тохиолдолд тухай бүр гүйцэтгэгчид сануулах, алданги тооцох, гэрээг цуцлах зэрэг шаардлагатай арга хэмжээг тухай бүр авах захиалагчийн чиг үүргийг тусгасан. Тодруулбал, захиалагчийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг юм.

Хуулийн төслийн 16.3 дахь хэсгийг төрийн байгууллагын эрх бүхий удирдах албан тушаалтан төсөл хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас төсөвт учруулсан хохирлыг бүрэн хариуцна хэмээн тайлбарлаж болно. Төсөвт учруулсан хохирол гэдэгт юуг ойлгох вэ гэдэгт Иргэний хууль болон Захиргааны ерөнхий хуулийн дагуу хариулах боломжтой. Иргэний хуулийн 227 дугаар зүйлд хохирол гэдэгт үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно хэмээн заасан. Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн үүднээс зардал, алдагдал буюу гэмтэл, зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцдог. Төсөвт учруулсан хохирол гэдгийг иргэний эрх зүйн үүднээс дээрх агуулгаар тодорхойлох эсэх нь эргэлзээтэй бөгөөд хэн, хэрхэн ямар журмаар тогтоох нь ойлгомжгүй байна.

Түүнчлэн, төслийг батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх бөгөөд зайлшгүй шаардлагын улмаас нэмэлт төсөв батлагдсан нөхцөлд уг нэмэлт зардлыг төсөвт учруулсан хохирол хэмээн үзэх эсэх нь маргаан үүсгэх эрсдэлтэй.

Захиргааны ерөнхий хуулийн Аравдугаар бүлэгт заасан хохирол барагдуулах, Иргэний хуулийн Тавин хоёрдугаар бүлэгт заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн зохицуулалтаар хуулийн төслийн 16.3-т тусгасан асуудал шийдвэрлэгдэх боломжтой байна.

Дүгнэлт: Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуулиар төсөвт учруулсан хохирлыг нэхэмжлэх боломжтой бөгөөд хуулийн төсөлд төсөвт учруулсан хохирлын хэмжээг хэн, ямар журмаар тогтоох нь тодорхой бус байна. Хуулийн төслийн 16.3 дахь хэсгийн захиалагч нь төсөвт учруулсан хохирлыг бүрэн хариуцах зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх тул 16.3 дахь хэсгийг хуулийн төслөөс хасахыг зөвлөж байна.

➤ **Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь заалт**

18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт

18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ:

18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

Үнэлгээ:

Хуулийн төслийн 18.2.2, 18.2.3-т орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар I, II ангиллын буюу 5 тэрбум хүртэл төгрөг, 5 тэрбумаас 20 тэрбум хүртэл төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл хэрэгжүүлэхээр заажээ.

Улсын төсвөөс татаас авдаггүй аймгийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч ихэнх нь улсын төсвөөс татаас дэмжлэг авдаг. Сүүлийн 3 жилийн төсвийн хуулиас дараах судалгаа хийв.

Хүснэгт 7.Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (сая төгрөг)		
		2025 он	2024 он	2023 он
1	Архангай	33,894.6	33,831.9	21,098.6
2	Баян-Өлгий	19,361.5	22,080.6	12,789.5
3	Баянхонгор	28,978.1	34,182.5	23,195.8
4	Булган		10,232.3	10,922.9
5	Говь-Алтай	19,659.6	26,065.0	18,485.8
6	Дундговь		18,195.6	16,965.5
7	Завхан	35,900.6	37,581.9	23,254.7
8	Өвөрхангай	21,883.1	27,680.8	21,597.4
9	Сүхбаатар	9,349.9	13,917.6	9,769.4
10	Төв		16,840.6	12,069.1
11	Увс	28,342.1	30,877.0	12,069.1
12	Ховд	4,875.8	12,982.1	12,290.4
13	Хөвсгөл	38,599.9	37,957.8	26,775.5
14	Хэнтий	27,305.8	38,777.6	25,201.7
15	Говьсүмбэр	5,119.7	6,836.4	2,378.2

Хүснэгт 8.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ

Д/д	Аймаг	Олгох шилжүүлгийн хэмжээ (сая төгрөг)		
		2025 он	2024 он	2023 он
1	Архангай	9,698.4	12,690.8	10,740.4
2	Баян-Өлгий	9,395.6	11,949.5	10,073.8
3	Баянхонгор	18,124.8	21,577.0	15,405.3
4	Булган	11,079.8	14,228.4	9,369.0
5	Говь-Алтай	18,303.7	17,357.4	15,122.9
6	Дархан-Уул	13,203.6	20,763.4	13,473.2
7	Дорноговь	33,362.2	42,708.1	26,870.3
8	Дорнод	22,933.7	25,422.0	21,499.5
9	Дундговь	13,039.8	25,422.0	11,875.4
10	Завхан	12,419.4	14,700.7	15,043.1
11	Орхон	39,536.7	34,710.3	16,970.4
12	Өвөрхангай	12,182.2	14,480.8	12,166.4
13	Өмнөговь	43,789.7	47,716.0	28,685.2
14	Сүхбаатар	19,709.5	18,215.7	17,153.8
15	Сэлэнгэ	23,056.1	27,768.4	20,328.8
16	Төв	24,987.5	28,366.8	20,671.3
17	Увс	10,770.9	13,069.0	11,324.0
18	Ховд	18,010.8	29,385.2	19,255.4
19	Хөвсгөл	14,457.7	16,739.1	14,403.3
20	Хэнтий	16,234.2	18,587.1	12,451.2
21	Говьсүмбэр	5,829.7	7,000.3	5,731.5
22	Улаанбаатар	39,536.7	50,167.0	41,325.1

Дээрх судалгаанаас харахад, Говьсүмбэр аймаг улсын төсвөөс олгох санхүүгийн бүх дэмжлэгээрээ жилдээ нэг I ангиллын төсөл, эсхүл хоёр жилдээ нэг I ангиллын төсөл хэрэгжүүлэхээр байна. Хэнтий аймаг улсын төсвөөс олгох санхүүгийн бүх дэмжлэгээрээ жилдээ нэг II ангиллын төсөл хэрэгжүүлэх боломжтой болно.

Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг үзвэл, Говьсүмбэр аймаг жилдээ нэг I ангиллын төсөл, Хэнтий аймаг жилдээ гурван I ангиллын төсөл хэрэгжүүлэхээр байна.

Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан хуулийн төслийн хэлэлцүүлэгт орон нутгийн нэгжийн албан хаагч "... I ангилал буюу 5 тэрбум төгрөгийн төслийг орон нутаг хэрэгжүүлэх хүндрэлтэй. Манай аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн нийт хөрөнгө 4 тэрбум төгрөг тул 5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийг орон нутаг хэрэгжүүлж чадахгүй. Сумын түвшинд орон нутгийн хөгжлийн санд 250 орчим сая төгрөг бий. Төрөөс олгодог санхүүгийн дэмжлэг нь урсгал зардалд зориулагддаг ба төрөөс хөрөнгө оруулалтад санхүүгийн дэмжлэг өгдөггүй ..." гэсэн санал гаргаж байв.¹⁶

Орон нутаг төсөв, санхүүгийн боломж хязгаарлагдмал нөхцөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас дэмжлэг авахгүй бол төсөл хэрэгжүүлэх боломжгүйд хүрнэ.

¹⁶ Төсвийн хөрөнгө оруулалтын хуулийн төслийн хэлэлцүүлгийн тайлан, Улаанбаатар, 2025 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр, 3 дугаар тал

Дүгнэлт: Хуулийн төслийн 18.2.2, 18.2.3 дахь заалт буюу орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар I, II ангиллын төсөл хэрэгжүүлэх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзлээ. Иймд, I, II ангиллын төслийг зөвхөн орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бус улсын төсвийн болон хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломжийг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.

➤ **Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсэг**

34 дүгээр зүйл.Тайлагналт, үр дүн

34.8.Захиалагч нь захиалагчийн техник, технологийн хяналт хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг, төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын зардлаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг тус тус дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнана.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 34.8-д дараах тайлан, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэхээр тусгажээ:

1. Захиалагч нь захиалагчийн техник, технологийн хяналт хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг;
2. Төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын зардлаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг.

Сангийн яамны судалгаагаар 2016 - 2024 онд 14.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл хэрэгжүүлснээс 5 - 6 хувь буюу 0.8 их наяд төгрөгийг бусад зардалд зарцуулсан. Тодруулбал, магадалшгүй ажлын зардалд 2 хувь, норм, нормативын сангийн зардалд 0.18 - 0.4 хувь, захиалагчийн хяналтын зардалд 2 хувь, 4 - 5 хувь, зохиогчийн хяналтын зардалд 1 хувь зэрэг болно.

Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжид "... Барилга байгууламжийн ажилд үе шатны хяналт гүйцэтгэж байгаа байгууллагын мэргэжлийн хүний нөөцийн хангамж, үр чадвар, мэргэшсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх;", "Барилга байгууламжийн үе шатны ажилд хяналт тавих үйл ажиллагаа, захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;" гэж тусгасан.¹⁷

Олон улсын байгууллагын тайланд "... төслийн хяналтын шинэчилсэн зохицуулалтыг Сангийн яамаар дамжуулан бий болгох. Эдгээр зохицуулалтын

¹⁷ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 107 дугаар тал

хэрэгжилт нь төслийн удаашралт, төсөвт өртгийн нэмэгдлийн давтамж, хамрах хүрээг хязгаарлахад тусална.” гэжээ.¹⁸

Сангийн яамнаас 2025 онд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдээр “... Захиалагчийн хяналт хангалтгүй, ... зохиогчийн хяналт сул, захиалагч байгууллагаас дарамт шахалт үзүүлдэг ...” гэсэн асуудал нэлээд давтагдсан болно.

Захиалагч тухайн жилдээ захиалагчийн техник, технологийн хяналтын зардлаар хэрэгжүүлсэн ажлын тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тайлагнах боломжтой бөгөөд энэ зохицуулалт нь захиалагчийн хяналтын тогтолцоог сайжруулах, улмаар төсвийн үргүй зардал гарахаас сэргийлэхэд эерэг нөлөөтэй болно.

Харин ажлын тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн мэдээллийг нэгдсэн маягт, аргачлалаар авах, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр хэрэгжүүлэх, захиалагчийн хяналтын тайланг цахим системээр илгээгээгүй нөхцөлд дараагийн санхүүжилт түдгэлзэх зэрэг зохицуулалт байх нь хэрэгжилтийг хангах нэмэлт хөшүүрэг болно.

Захиалагчийн техник, технологийн хяналт гэх нэр томъёоны талаар холбогдох хууль, журамд хэрхэн тусгасныг авч үзье.

- Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд барилгын үе шатны ажлын хяналт гэж;
- Авто замын тухай хуулийн 21, 28 дугаар зүйлд захиалагчийн хяналт гэж;
- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.8, 2.9, 3.4, 3.5, 3.9, 3.12, 3.14-т захиалагчийн техникийн хяналт гэж;
- Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.5, 4.2.2.7, 4.3.4.11, д захиалагчийн техник, технологийн хяналт гэж;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 1.2, 4.2-т техник, технологийн хяналт гэж;
- Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын дүрэм”-д захиалагчийн техникийн хяналт хэмээн тусгагдсан байна.

Дээрх хууль, захиргааны актад захиалагчийн техник, технологийн хяналт гэх нэр томъёог ялгаатай тусгасан байх тул нийтлэг байдлаар ойлгох боломжтой нэр томъёог хэрэглэх нь зүйтэй.

Хуулийн төслийн 43 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болон сангийн удирдлага, зохион байгуулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх, 46 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн ил тод байдал, тайлагналтын талаар зохицуулжээ.

¹⁸ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 112 дугаар тал

Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн төсөвт өртгийн 0.18 – 0.4 хувь нь норм, нормативын санд төвлөрдөг байсныг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болгон зохион байгуулж, тус сангийн удирдлага, зохион байгуулалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулжээ.

Иймд,, хуулийн төслийн 34.8 дахь хэсгийн төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын зардлаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнана гэсэн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй байна.

Дүгнэлт: Хуулийн төслийн 34.8 дахь хэсгийн захиалагч нь тухайн жилдээ захиалагчийн хяналтын зардлаар хэрэгжүүлсэн ажлын тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тайлагнах гэсэн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой.

Харин хуулийн төслийн 34.8 дахь хэсгийн төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын зардлаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнана гэсэн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй байна. Иймд, хуулийн төслөөс 34.8 дахь хэсгийн уг зохицуулалтыг хасах, эсхүл өөрчлөн сайжруулахыг зөвлөж байна.

➤ **Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.1 хэсэг**

43 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан

43.1.Барилга, авто зам, төмөр зам болон эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарын технологийн хөгжлийг дэмжих, норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилго бүхий төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сантай байна.

Үнэлгээ:

Үндэсний аудитын газрын 2023-2025 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжид:

- “Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо норм, нормативын зардлыг холбогдох байгууллагад шилжүүлээгүй;
- Барилгын салбарт мөрдөж байгаа норм, дүрмийн шинэчлэл хийгдэхгүй хугацаа алддаг, цалин, тариф, үнийн индекс, нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ хуучирсан зэргээс шалтгаалан барилга угсралтын ажил удааширч зураг төслийн дагуу гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэж байна. Норм, нормативын санд төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй үлдэгдэлтэй;
- Барилга байгууламжийн гүйцэтгэлд тулгардаг нийтлэг асуудалд үндэслэн зураг төслөө өөрчлөх, чанаргүй гүйцэтгэх шалтгаан нөхцөлийг судалж, холбогдох норм, дүрмийг шинэчлэх шаардлага үүссэн;
- Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд гарч байгаа нийтлэг зөрчил, асуудалд судалгаа, шинжилгээ хийж, барилгын норм,

дүрэм, стандартыг өөрчлөн шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах, норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах” гэжээ.¹⁹

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “... Барилга, эрчим хүч, авто зам зэрэг салбарын норм, нормативын санд төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас ижил хувь хэмжээгээр хөрөнгө төвлөрүүлдэг хэдий ч норм нормативын баримт бичгийг шинэчлэх ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг, хариуцлагын тогтолцоо сул болох нь холбогдох хяналт шалгалтаар тогтоогдсон. Төсвийн хөрөнгө ийнхүү үр ашиггүй зарцуулагдаж буйг өөрчилж, норм, нормативын сангийн удирдлага, менежментийг шинэчлэх шаардлагатай;” гэж дурдсан байна.

Барилга, авто зам, төмөр зам болон эрчим хүчний тухай хууль тогтоомжид заасан тухайн салбарын норм, нормативын сангийн тодорхой хэсэг буюу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн норм, нормативын санд төвлөрөх хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болгон өөрчлөн зохион байгуулна. Харин тухайн салбарт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт үл хамаарах бусад эх үүсвэрээр төсөл хэрэгжих нөхцөлд норм, нормативын санд хөрөнгө төвлөрөхтэй холбоотой одоогийн зохицуулалт хэвээр үйлчилнэ. Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль болон Эрчим хүчний тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсан нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн зохицуулалтыг практикт хэрэгжих, уялдаа холбоог хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дүгнэлт: Хуулийн төслийн 43.1 дэх хэсэг буюу төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

➤ **Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.4, 47.5 дахь хэсэг**

47 дугаар зүйл.Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

47.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэгчийг нийт гүйцэтгэсэн төслийн гүйцэтгэл, үр дүнд үндэслэн дараах шалгуур үзүүлэлтээр жил тутамд үнэлнэ:

47.1.1.төслийн чанар, стандартын болон аюулгүйн шаардлага хангасан байдал;

47.1.2.төслийн хэрэгжүүлсэн хугацаа;

47.1.3.төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэгжүүлсэн байдал;

47.1.4.төслийн үр өгөөж, ашиглагч болон олон нийтийн үнэлгээ;

47.1.5.ногоон технологи хэрэглэсэн байдал, байгаль орчин болон хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан үнэлгээнд үндэслэн гүйцэтгэгчийг дараах жагсаалтад хамруулна:

47.2.1.сайн гүйцэтгэлтэй буюу “ногоон”;

47.2.2.дундаж гүйцэтгэлтэй буюу “шар”;

47.2.3.хангалтгүй гүйцэтгэлтэй буюу “улаан”.

¹⁹ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын Тандан судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2025 он, 107 дугаар тал

47.4.Төслийн гүйцэтгэгчийг дараах байдлаар урамшуулна:

47.4.1.худалдан авах ажиллагаанд ижил үнэлгээтэй хэд хэдэн тендер байх тохиолдолд энэ хуулийн 47.2-т заасан гүйцэтгэгчийн жагсаалтын дагуу эрэмбэлнэ;

47.4.2.гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр олгоход “ногоон” жагсаалтын гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардахгүй, “шар” жагсаалтын гүйцэтгэгч төлбөрийн 50 хувьтай тэнцэх дүнгийн баталгаа ирүүлнэ.

47.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 47.1-д заасан үнэлгээнд үндэслэн “улаан” жагсаалтын гүйцэтгэгчийн төрийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг гурван жилийн хугацаагаар хязгаарлаж болно.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 47.1-д төслийн гүйцэтгэгчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн гүйцэтгэл, үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлтээр жил тутамд үнэлэхээр тусгажээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл хангалтгүй, баригдсан барилга байгууламж нь чанаргүй, хугацаандаа ашиглалтад ордоггүй гэдэг шүүмжлэл гардаг хэдий ч тухайн компани дараагийн төслийн ажлаа эхлүүлсэн байдал цөөнгүй бий. Иймд, төслийн гүйцэтгэгчийн хариуцлагыг сайжруулах, төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагаар төслийн гүйцэтгэгчийг хийсэн ажлын үр дүнгээр нь үнэлэх нь зүйтэй. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн гүйцэтгэгчийн үнэлгээг хийх тул төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг ашиглах боломж нээлттэй байна.

Хуулийн төслийн 47.1.2-т “төслийн хэрэгжүүлсэн хугацаа”, 47.1.3-т “төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэгжүүлсэн байдал” гэсэн хэсэг нь ойлгомжгүй байх тул 47.1.2-ыг “төсөл хэрэгжсэн хугацаа” гэж, 47.1.3-ыг “төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан байдал” гэж өөрчлөхийг зөвлөв.

Хуулийн төслийн 47.2-т төслийн гүйцэтгэгчийг ногоон, шар болон улаан жагсаалтад хамруулахаар заажээ. Энэ нь Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн төслийн гүйцэтгэгчийг гүйцэтгэлээр нь үнэлэх, үнэлгээ олон нийтэд ил тод, нээлттэй байх, өнгөөр үнэлэх зөвлөмжтэй нийцнэ.

Төслийн гүйцэтгэгчийн ногоон, шар болон улаан жагсаалтад үндэслэн урамшуулах болон хариуцлага тооцох зохицуулалтыг хуулийн төслийн 47.4, 47.5-д заажээ. Төслийн гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлсний мөрөөр зохих өнгийн жагсаалтад хамруулаад үр дагаварт нь ямар нэгэн байдлаар урамшуулал, хариуцлагын талаар зохицуулахгүй бол өмнөх зохицуулалтын үр нөлөө гарахгүй болно.

“Ногоон” жагсаалтын гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардахгүй, харин “шар” жагсаалтын гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн 50 хувьтай тэнцэх дүнтэй баталгаа шаардахаар тусгасныг шударга ёсны зарчимд нийцсэн хэмээн үзнэ. Харин “улаан” жагсаалтын гүйцэтгэгчийн төрийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг гурван жилийн хугацаагаар хасахаар тусгасан нь Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.8-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын байцаагчийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор аж ахуй эрхлэгчийг тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад гурван жилийн хугацаагаар бүртгэх шийдвэрийг гаргана.” гэж заасантай нийцнэ.

Дүгнэлт: Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.4, 47.5 дахь хэсэг практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ. Төслийн гүйцэтгэгчийн үнэлгээг хүнээс аль болох хамаарал багатай байдлаар буюу төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр хэрэгжүүлэх боломжийг судлах нь зүйтэй.

4.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Уг үнэлгээний тайлангийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслөөс сонгож авсан зүйл, хэсэг, заалтын ойлгомжтой байдлыг үнэлэв.

➤ Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 4.1.11, 4.1.12, 4.1.20 дахь заалт

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.18.“техник, технологийн хяналт” гэж төсөл батлагдсан зураг төсөл, төсөв, холбогдох норм, норматив, техникийн баримт бичиг болон гэрээнд заасны дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.19.“техник, эдийн засгийн үндэслэл” гэж төслийг хэрэгжүүлэх боломж, технологийн шийдэл, байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж тооцсон, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ашиглагдах иж бүрэн судалгаа, дүн шинжилгээнд суурилсан баримт бичгийг;

Үнэлгээ:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан бөгөөд 4.1.18, 4.1.19 дэх заалтаар “техник, технологийн хяналт” болон “техник, эдийн засгийн үндэслэл” гэсэн нэр томьёог тус тус томьёолсон байна.

4.1.18 дахь заалтын “техник, технологийн хяналт” гэсэн тодорхойлолтод “төсөл ... гэрээнд заасны дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих” гэсэн нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах төсөл хэрэгжүүлэх гэрээ, эсхүл захиалагч болон техникийн хяналт хэрэгжүүлэгчийн хооронд байгуулах гэрээ гэж хоёрдмол утгатай ойлгогдох боломжтой байна. Иймд, уг тодорхойлолтын “гэрээнд” гэснийг “төсөл хэрэгжүүлэх гэрээнд” гэж тодотгон өөрчлөх нь зүйтэй.

4.1.19 дэх заалтын “техник, эдийн засгийн үндэслэл” гэсэн тодорхойлолтод “төслийг хэрэгжүүлэх боломж, технологийн шийдэл, байршил, хүчин чадал, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, байгаль орчны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж тооцсон” зэрэг техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д тусгагдах үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхой дурдсан нь зүйтэй боловч хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт ТЭЗҮ-ийн тайланд тусгах агуулгыг илүү нарийвчлан зохицуулсан байна. 4.1.19 дэх заалтын тодорхойлолтын хүрээнд багтах

боловч 22.1 дэх хэсгийн зарим шаардлагыг хангаагүй бол тухайн баримт бичгийг бүрэн, хүчин төгөлдөр ТЭЗҮ гэж үзэх эсэх талаар ойлгомжгүй байдал үүсэх эрсдэлтэй байна. Иймд уг тодорхойлолтын “баримт бичгийг” гэснийг “энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан баримт бичгийг” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт**

5 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарчим

5.1.2.төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээнд үндэслэсэн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн өгөөжтэй байх буюу үр ашигтай байх зарчим;

Үнэлгээ:

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тусгасан бөгөөд 5.1.2-т “төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээнд үндэслэсэн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн өгөөжтэй байх буюу үр ашигтай байх зарчим”-ыг тусгасан байна. Уг заалтад хэрэглэсэн “эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээ” гэх хэллэг нь хуулийн төслийн бусад зохицуулалтад (жишээлбэл: 11.1.6, 12.1.11, 23.1, 23.3) “нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох шинжилгээ” гэж хэрэглэсэнтэй зөрчилдөж байна. Иймд, хуулийн төслийн нэр томъёо, хэллэгийг нэг мөр болгон уялдуулах зорилгоор 5.1.2-т “эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээнд” гэснийг “нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох шинжилгээнд” гэж өөрчлөх нь зүйтэй.

➤ **Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг**

9 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйл

9.6.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эрх бүхий этгээдээс нэмэлт санхүүжилтийг энэ хуульд зааснаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төсвөөс нэмэлт эх үүсвэр, санхүүжилтийг төлөвлөх, санхүүжүүлэхийг хориглоно.

Үнэлгээ:

Уг зохицуулалт нь төсвийн сахилга, хариуцлагыг хангах, төслийн санхүүжилтийн хязгаарыг тодорхой болгох зорилготой, ерөнхий агуулгын хувьд хуулийн төслийн зорилго, зарчимтай нийцэх боловч “энэ хуульд зааснаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд” гэсэн нь ямар нөхцөл, журмаар нэмэлт санхүүжилт олгохыг тодорхой заагаагүй тул практикт төсөл хэрэгжүүлэгч этгээдийн зүгээс нэмэлт санхүүжилт шаардах үндэслэл, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн хүрээ тодорхойгүй байх эрсдэлтэй. Иймд, уг хэсэгт хуулийн аль зүйл, хэсэгт заасан тохиолдлыг хэлж буйг тодорхой эш татан заах, эсхүл нэмэлт санхүүжилт олгох нөхцөл, шалгуурыг нарийвчлан тусгах шаардлагатай байна.

➤ **Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт**

13 дугаар зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх

13.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.төсвийн хөрөнгө оруулалтын шилжих болон шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.3-т заасны дагуу үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

Үнэлгээ:

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг тодорхойлсон бөгөөд 13.1.1 дэх заалтад “төсвийн хөрөнгө оруулалтын шилжих болон шинээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 24.2.3-т заасны дагуу үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн бүрэн эрхийг тусгасан байна. Хуулийн төслийн 4.1.23-д заасны дагуу “төсвийн ерөнхийлөн захирагч” гэдэгт Төсвийн тухай хуулийн 14.1-д заасан албан тушаалтныг ойлгох бөгөөд Төсвийн тухай хуулийн 14.1.20-д зааснаар орон нутгийн төсвийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч нь Засаг дарга байна.

Хуулийн төслийн 13.1.1-д ямар эх үүсвэрийн төсөл гэдгийг тусгайлан заагаагүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын бүхий л эх үүсвэрт хамаарах зохицуулалт гэж ойлгогдохоор байна. Гэвч энд эшилсэн хуулийн төслийн 24.2.3 дахь заалт нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хувьд тусгайлан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хийх үнэлгээний талаарх зохицуулалт байна. Харин Засаг даргын хийх үнэлгээний талаар 24.2.1, 24.2.2-т зохицуулсан. Иймд, 13.1.1 дэх заалт нь зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах бүрэн эрх байх тул уг заалтын “төсвийн хөрөнгө оруулалтын” гэснийг “улсын төсвийн хөрөнгө оруулалтын” гэж өөрчилж хуулийн төслийн зүйл, заалтын хоорондох уялдааг хангах шаардлагатай.

➤ **Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт**

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх

14.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн өргөн мэдүүлснээр хэлэлцэж, энэ хуульд заасан зарчим, төсөлд тавигдах нийтлэг шаардлага, төслийн ангилал, зориулалтыг баримтлан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн батлах;

Үнэлгээ:

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн

бүрэн эрхийг тусгасан бөгөөд 14.1.1 дэх заалтад “орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн өргөн мэдүүлснээр хэлэлцэж, ... батлах” бүрэн эрхийг заасан байна. Эдгээр зохицуулалт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн хувьд төслийн жагсаалтыг Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэж батлах бөгөөд хот, тосгоны хувьд Захирагчийн өргөн мэдүүлснээр Зөвлөл хэлэлцэж батлах тухай ялган тодорхойлсон нь Төсвийн тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай нийцсэн, хууль тогтоомж хоорондын уялдааг хангасан бөгөөд хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой боловсруулагдсан байна.

➤ **Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг**

18 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, зориулалт

18.2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр дараах зорилго, зориулалт бүхий төслийг хэрэгжүүлнэ:

18.2.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан зорилго, зорилтыг хангах, тогтвортой хөгжилд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй, төрийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.2.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, ногоон орчин бүрдүүлэх, цахим шилжилт, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.3.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн дэд бүтцийг шинэчлэх, иргэдийн хөгжлийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, нэмэгдүүлэх, ногоон байгууламж, орчны тохижилтыг нэмэгдүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын I – II ангиллын төсөл;

18.2.4.гадаадын зээлийн санхүүжилтээр хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааны бодлого, зорилготой уялдсан, эдийн засгийн үр ашиг, өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нарийн төвөгтэй техник технологи шаардсан, нийгмийн ач холбогдолтой, урт хугацаанд үр өгөөжөө хадгалах, дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II – V ангиллын төсөл;

18.2.5.гадаадын тусламжийн санхүүжилтээр энэ хуулийн 18.2.4-т зааснаас гадна хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түншээс Монгол Улсын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан салбар, зориулалт хязгаарлахгүй, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулж, хүний хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой төсвийн хөрөнгө оруулалтын бүх ангиллын төсөл;

18.2.6.төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилт нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан зорилго, нөхцөл бүхий төсвийн хөрөнгө оруулалтын III – V ангиллын төсөл.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр ямар зориулалт, ангиллын төслийг хэрэгжүүлэх

талаар зохицуулсан байна. Энэ нь хуулийн төслийн зорилготой уялдсан, төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай, оновчтой хэрэгжүүлэх зарчимд нийцсэн зохистой зохицуулалт болсон байна. Гэвч хуваарилалтын хувьд зарим эх үүсвэрийн зориулалт, төслийн ангилал давхцаж байх тохиолдолд аль эх үүсвэрийг сонгох талаар зохицуулалт байхгүй байна. Жишээлбэл: нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах зорилготой II ангиллын төслийг улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой байна. Энэ тохиолдолд гурван эх үүсвэрээс алийг нь оновчтой тодорхойлж сонгох талаар нарийвчилсан зохицуулалт тусгаж хуулийн төслийг илүү боловсронгуй, тодорхой болгох боломжтой байна.

Мөн 18.2.4, 18.2.5 дахь заалтад “хөгжлийн түнш” гэсэн нэр томьёо ашигласан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх” гэсэн шаардлагад нийцэхгүй байна. Иймд, 18.2.4 дэх заалтад “хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын” гэснийг “олон улсын байгууллага, түнш орны” гэж, 18.2.5 дахь заалтад “хөгжлийн түншээс” гэснийг “олон улсын байгууллага, түнш орноос” гэж тус тус өөрчилж, хуулийн төслийн нэр томьёог Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн нэр томьёотой нийцүүлэх шаардлагатай.

➤ **Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг**

21 дүгээр зүйл.Техник, эдийн засгийн үндэслэл

21.2.Шинэ техник технологи, инноваци нэвтрүүлэх энэ хуулийн 7.1-д заасан I, II болон III ангиллын төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай эсэхийг төслийн онцлог, цар хүрээнээс хамаарч, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх төсөлд техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийх шаардлагатай эсэхийг тодорхойлохтой холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Энэ нь өндөр өртөг бүхий төсөлд хамаарахгүй боловч шинэлэг, технологийн өндөр эрсдэлтэй төслүүдэд уян хатан хандлага баримтлах боломжийг олгох оновчтой зохицуулалт болсон байна. Гэвч ямар субъект ямар төслийг “шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх төсөл” гэж үзэж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэхийг тодорхой заагаагүй байгаа нь хэрэгжилтийн шатанд ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэлтэй юм. Өөрөөр хэлбэл I-III ангиллын бүх төслийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн харгалзан үзэж, ТЭЗҮ хийх шаардлагыг тодорхойлох уу, эсхүл аль нэг өөр субъект бүх төслүүд дундаас тодорхой төслийг “шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх төсөл” гэж сонгон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх үүрэгтэй юу гэдгийг зохицуулаагүй байна. Иймд, холбогдох төслийг тодорхойлох шалгуур, шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан тусгах нь хуулийн хэрэгжилтийн тодорхой байдал, үр нөлөөг дээшлүүлэхэд ач холбогдолтой юм.

➤ **Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.4.3 дахь заалт**

29 дүгээр зүйл.Төслийн гэрээний удирдлага

29.4.Төсөл хэрэгжүүлэх гэрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.3-т зааснаас гадна дараах нөхцөлийг тусгана:

29.4.3.гэрээний нийт үнийн дүнг батлагдсан төсвийн дагуу зардлын нэр төрөл бүрээр буюу барилга угсралт, төсөл хэрэгжүүлэхэд тавих хяналт, магадалшгүй ажил, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болон зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг зөвлөх үйлчилгээний зардал /нэг бүрчлэн/;

Тайлбар:“Магадалшгүй ажил” гэдэгт зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдаагүй бөгөөд ажлын явцад бий болох нэмэлт, өөрчлөлт, зайлшгүй шаардлагатай ажлын зардлыг ойлгоно.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт төсөл хэрэгжүүлэх гэрээнд тусгах нөхцөлийг тодорхойлсон бөгөөд 29.4.3 дахь заалтад гэрээний нийт үнийн дүнг зардлын нэр төрөл бүрээр тусгахаар зохицуулсан байна. Үүнд магадалшгүй ажлын зардлыг хамруулсан бөгөөд ““магадалшгүй ажил” гэдэгт зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдаагүй бөгөөд ажлын явцад бий болох нэмэлт, өөрчлөлт, зайлшгүй шаардлагатай ажлын зардлыг ойлгоно” гэсэн нэр томъёоны тайлбарыг тусгасан байна. Уг тайлбараас харахад магадалшгүй ажил гэдэг нь төсөл хэрэгжих явцад гарсан, төсөл анх эхлэх үед тодорхойгүй, төлөвлөгдөөгүй байсан нэмэлт ажил гэж ойлгогдож байна. Гэтэл төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө байгуулах гэрээнд хэрхэн энэ ажлын зардлыг урьдчилан тусгах нь ойлгомжгүй, энэ талаар хуулийн төсөлд өөр нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Иймд, магадалшгүй ажлын зардлыг хэрхэн тодорхойлж төсөл хэрэгжүүлэх гэрээнд заах талаар зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах шаардлагатай.

➤ **Хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг**

33 дугаар зүйл.Төсөвт өртгийн өөрчлөлт

33.6.Захиалагч, захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь энэ хуульд заасныг зөрчиж төсөвт өртгийг нэмэгдүүлэх аливаа шийдвэр гаргасан эсхүл төсөвт өртгийг нэмэгдүүлэх тухай гаргасан хүсэлт нь энэ хуулийн 33.4-т заасан дүгнэлтээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд захиалагчийн техникийн хяналтын болон зохиогчийн хяналтын зардлыг холбогдох төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт буцаан төвлөрүүлнэ.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт захиалагч, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч этгээд хуулийн шаардлагыг зөрчиж төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгасан байна. Энэ нь төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын үр ашиг, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлд чухал ач холбогдолтой зохицуулалт байна. Нөгөөтээгүүр хэт хатуу хэрэглэгдсэн тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоонд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Хэрэв зохиогчийн болон техникийн

хяналтын байгууллагууд аливаа төсөлд оролцохдоо шууд санхүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй бол тэд өндөр эрсдэлтэй, шинэлэг төслүүдэд оролцохоос татгалзах хандлагатай болох магадлалтай бөгөөд үүний улмаас мэргэшсэн, туршлагатай хяналтын инженер, зөвлөхүүдийн оролцоо буурч, төсөл хэрэгжүүлэх чанар, хяналтын мэргэжлийн түвшин доройтох эрсдэлтэй гэдгийг анхаарах нь зүйтэй.

➤ **Хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг**

41 дүгээр зүйл. Хөрөнгийн ашиглалт, сайжруулалт

41.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын дүнд бий болсон хөрөнгийг ашиглалтад оруулах үед цахим систем дээр хөрөнгийн бүртгэлтэй уялдуулан кодлох бөгөөд энэхүү бүртгэлээр тухайн хөрөнгийн шаардлагатай засвар, сайжруулалтын хуваарь, хугацааг урьдчилан тодорхойлдог байна.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэх, кодлох, засвар, сайжруулалтын хуваарь, хугацааг урьдчилан тодорхойлох зохицуулалтыг тусгасан байна. Энэ нь хөрөнгийн үр ашиг, тогтвортой байдлыг хангах, засвар үйлчилгээний төлөвлөлтийг сайжруулах чиглэлд эерэг үр дүнтэй зохицуулалт болсон байна. Гэвч бүртгэл, кодчилал, хуваарь гаргах ажлыг ямар субъект хянах, баталгаажуулах, тухайн хөрөнгөд хамаарах засвар, сайжруулалтын стандарт хуваарь, хугацааг хэрхэн тогтоодог байх нь тодорхой бус байна. Иймд, холбогдох хяналт, баталгаажуулалтын үүрэг, стандарт аргачлалыг хуульд, эсхүл холбогдох журамд нарийвчлан тусгах нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

➤ **Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг**

47 дугаар зүйл. Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх

47.6. “Улаан” жагсаалтын гүйцэтгэгч болон түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан “улаан” жагсаалтад байх хугацаандаа шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр, эсхүл бусад хуулийн этгээдээр дамжуулан төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлд оролцохыг хориглоно.

Үнэлгээ:

Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг нь “улаан” жагсаалтын гүйцэтгэгч болон түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд оролцохыг хориглох зохицуулалтыг тусгасан байна. Энэ хэсэг нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, шударга өрсөлдөөн, хариуцлагын тогтолцоог хамгаалах чиглэлд эерэг ач холбогдолтой байна. Харин уг хэсэгт “шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр, эсхүл бусад хуулийн этгээдээр дамжуулан” гэж дурдсан боловч энэ нөхцөлийг хэрхэн тогтоох нь, ямар хэмжээнд хязгаарлах нь тодорхойгүй байна. Хувьцаа эзэмшлийн хувь, оролцооны хэмжээг тодорхой зааж өгөөгүй нь маргаан үүсгэх эрсдэлтэй. Мөн энэ хоригийг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэгчийн хувьцаа эзэмшигчид, удирдлагын бүрэлдэхүүн, санхүүгийн хамаарал, гэрээний эрх, ашиг сонирхол зэрэг бүх холбоог нарийвчлан шалгах

шаардлага үүснэ. Гэтэл ийнхүү шалгалт хийх боловсон хүчин, чадамж, практикт хэрэгжих боломж бий эсэхийг анхаарах нь зүйтэй юм.

Үнэлгээ: Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

Түүнчлэн хуулийн төслийг нийтэд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хүснэгт 9.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн тогтолцоог тодорхойлж, төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг хамруулан, төсвийн хөрөнгө оруулалтын үе шат бүрийн зохицуулалтыг бүрэн тусган байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл нь зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн дийлэнх зохицуулалт, бичвэр уг шаардлагыг хангасан байна. Дээр дурдсанчлан хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг хуулийн төслийн холбогдох бусад зохицуулалттай уялдаа холбоог шалгах нь зүйтэй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төслийн хүрээнд бусад хуулийн заалтыг давхардуулан заагаагүй, шаардлагатай тохиолдолд бусад хуулийн холбогдох зохицуулалтыг эш татсан байх тул энэ шаардлагыг хангасан байна.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн	Уг шаардлагыг хангасан байна.

харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	
--	--

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан нь хуулиар тавигдсан шаардлага болон ойлгомжтой байх шалгуур үзүүлэлтийг хангасан байна гэж дүгнэлээ.

4.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь өөр хоорондоо болон Монгол Улсын бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэхийг аргачлалд заасан шалгуур асуултын хүрээнд шалгаж тогтоолоо.

Хүснэгт 10. Хуулийн төслийг харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

№	Асуулт	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгодоо нийцсэн.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Нийцсэн байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна. Жишээлбэл, хуулийн төсөлд “авто зам”, “барилга байгууламж”, “төсвийн ерөнхийлөн захирагч” зэрэг нэр томьёог Авто замын тухай хууль, Барилгын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн нэр томьёотой нийцүүлэн ашигласан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна. Жишээлбэл, хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын ил тод, нээлттэй байдлын талаарх зохицуулалт (<i>тухайлбал: 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 35-36 дугаар зүйл</i>) нь хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад заасан ил тод байдлын зарчим, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “ил тод байдлыг хангасан байх”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтад “ил тод, нээлттэй байх” гэсэн зарчимтай нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зохицуулалтаар Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл болон бусад хууль хооронд давхардал үүсэх зохицуулалт агуулаагүй байна.

6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төсөлд холбогдох чиг үүрэг, хэрэгжүүлэх субъектүүдийг тодорхой тусгасан байна. Тухайлбал, Засгийн газрын бүрэн эрх, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх, захиалагчийн чиг үүрэг гэх мэт.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тодорхой зохицуулаагүй байсан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг зохицуулж, Монгол Улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, төслийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт, тайлагналттай холбоотой нэгдмэл зохицуулалтыг тусгасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг зохицуулсан бөгөөд ийнхүү тусгахдаа аливаа давхардал үүсгээгүй байна.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт "... төсөлд тавих захиалагчийн техник хяналтыг захиалагч болон гүйцэтгэгчээс <u>хараат бус, мэргэжлийн эрх бүхий этгээдээр хэрэгжүүлж болно</u> " гэж, 32.5 дахь хэсэгт "Төсөл хэрэгжүүлэхэд хийгдэх захиалагчийн техник хяналтыг тендер шалгаруулалтын үндсэн дээр эрх бүхий <u>мэргэжлийн этгээдээр зөвлөх үйлчилгээний гэрээгээр гүйцэтгүүлнэ</u> " гэж тус тус зохицуулсан.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Ийм зохицуулалт тусгагдаагүй байна.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй. Харин хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтад төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт хийсэн байхаар, 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтад төслийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох шинжилгээнд нийгмийн зорилтот бүлэгт үзүүлэх

		нөлөөллийг тусгасан байхаар тус тус зохицуулсан нь хүний эрхийг дэмжихэд ач холбогдолтой зохицуулалт болсон байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтад төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт хийсэн байх тухай жендерийн тэгш байдлыг хангах зохицуулалт тусгасан.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна. Харин хуулийн төслийн 47 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг гүйцэтгэлд тулгуурлан үнэлж, урамшуулах талаар зохицуулсан нь шударга өрсөлдөөнийг дэмжсэн зохицуулалт байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төслийн 51 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан. Мөн дагалдан гарах хуулийн төслийн хүрээнд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах байдлаар хуулийн төсөл боловсруулсан байна.

ТАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Үнэлгээ:

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэллээ. Уг хуулийн төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалт гэсэн дараалсан 5 үе шатыг зохицуулжээ. Эдгээр үе шат бүрд оролцогчид нь хэн болох, тухайн зохицуулалтад хүний эрхэд нөлөөлөх ямар зохицуулалт тусгагдсан эсэхийг дараах байдлаар үнэлэв.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатны үндсэн хэсэг нь бэлтгэл үе шат байдаг. Бэлтгэл үе шатанд төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв боловсруулах болон шаардлагатай бусад зөвшөөрөл авах ажиллагаа хийгдэнэ. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл боловсруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Иргэний хуулийн дагуу зохих ёсоор гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд гүйцэтгэх боломжтой. Өөрөөр хэлбэл, бэлтгэл үе шатанд ихэвчлэн хуулийн этгээд, зарим нөхцөлд иргэн оролцох боломжтой хэмээн үзвэл эдгээр нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх байдлаар оролцоно. Иймд, төслийн төлөвлөлтийн бэлтгэл үе шатны зохицуулалт нь хүний эрхэд нөлөөлөх хэм хэмжээ агуулаагүй байна.

Бэлтгэл ажил хангагдсан нөхцөлд төслийн төлөвлөлт хийгдэнэ. Төслийн төлөвлөлтөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс эхлэн оролцох буюу сум, дүүргийн Засаг дарга төслийн саналаа гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, аймаг, нийслэлийн Засаг дарга нь төслийн саналыг үнэлж эрэмбэлэн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч нь салбарын хэмжээнд төслийн саналыг нэгтгэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Иргэд орон нутагтаа хэрэгжүүлэх төслийн талаар саналаа өгөх эрхтэй буюу орон нутаг иргэдийн саналыг авах үүрэгтэй байхаар хуулийн төсөлд тусгажээ. Тодруулбал, төслийн төлөвлөлтийн үе шатанд иргэд саналаа өгөх эрхтэй, харин төрийн байгууллага, албан тушаалтан төслийн саналыг үнэлж эрэмбэлэн хүргүүлэх үүрэгтэй байна. Иймд, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатны зохицуулалт нь хүний эрхэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй бөгөөд иргэдийн оролцоог хангасан байна.

Төслийн хэрэгжилтийн үе шатанд эрх шилжүүлэх, багц хуваарилах болон гэрээний удирдлагын харилцаа хамаарна. Эрх шилжүүлэх, багц хуваарилах харилцаа нь төрийн эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлэх үйл ажиллагаа болно. Харин төслийн гэрээний удирдлагын харилцаанд зохих хууль тогтоомжийн хүрээнд гэрээний тал болсон хуулийн этгээд оролцоно. Төслийн хэрэгжилтийн үе шатны зохицуулалтад хүний эрхэд нөлөөлөх хэм хэмжээ тогтоогдсонгүй болно.

Төслийн санхүүжилтийн үе шатанд захиалагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт хэрэгжүүлэгч болон

гүйцэтгэгч оролцоно. Төслийн гэрээний үүрэг бүрэн биелсэн эсэхийг эрх бүхий этгээд хянан баталгаажуулснаар санхүүжилтийг шилжүүлнэ. Иймд, төслийн санхүүжилтийн үе шатны зохицуулалтад хүний эрхэд нөлөөлөх байдал тогтоогдсонгүй болно.

Төслийн хяналт, тайлагналтын үе шатанд захиалагчийн хяналт, захиалагчийн техникийн хяналт, зохиогчийн хяналт болон захиалагчийн тайлагналт, төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлагналтын талаар зохицуулжээ. Төслийн хяналт, тайлагналтын харилцааг ойлгомжтой, тодорхой хуулийн төсөлд тусгасан нь үндсэн агуулгын хувьд хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахад чиглэсэн байна.

Хөрөнгийн удирдлага, ашиглалтын харилцаанд төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулсан хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор захиалагч, гүйцэтгэгч, бусад этгээдийн гүйцэтгэх чиг үүргийг зохицуулсан байх бөгөөд энд хүний эрхэд сөргөөр нөлөөлөх байдал тогтоогдсонгүй.

Төсвийн хөрөнгө оруулалтаар авто зам, эрчим хүч, инженерийн дэд бүтэц зэрэг нийтийн зориулалттай дэд бүтэц, бүтээн байгуулалтууд, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, музей, соёлын төв, захиргааны байр зэрэг төрийн үйлчилгээний барилга байгууламжуудыг барьж байгуулах төслийг хэрэгжүүлдэг. Энэ нь иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэхээс гадна эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төрөөс иргэдэд хүргэх нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэж, төрийн байгууллага, албан тушаалтны төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны үе шат бүрд хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулсан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн гэж үзлээ.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын²⁰ дагуу үнэлж, дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

ДҮГНЭЛТ:

- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан буюу хуулийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан байна.
- Хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй байна.
- Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёолсон байна.
- Хуулийн төсөлд хүний эрхэд сөргөөр нөлөөлөх зохицуулалт тусгагдаагүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл нь хүний эрхийг хангах, төрөөс иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд чиглэсэн байна.
- Иймд, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл нь эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага болон хуулийн төслийн уялдаа холбоог хангасан байна гэж үзлээ.

Аргачлалд заасан доор дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлт гаргав.

• “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр

Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан зорилгыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн 5 ангилал, төслийн 4 төрлийг тодорхой болгон заажээ. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэл хэмээн тодорхойлж, тэдгээр эх үүсвэрээр ямар төсөл хэрэгжүүлэхийг зохицуулсан байна.

Төслийн бэлтгэл үе шатны үндсэн асуудал болох техник, эдийн засгийн үндэслэлд хамаарах зохицуулалт бий болгож, ямар төсөлд техник, эдийн засгийн үндэслэл заавал хийх, эсхүл хийж болох, зардлын дээд хязгаар хэд байхыг тусгасан. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн сан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлснээр нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээж

²⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>

зохицуулжээ. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн үр өгөөжийг тооцох, ашиглалтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд заасан болно.

- **“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр**

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл практикт хэрэгжих боломжтой байна. Уг хуулийн төслөөр зохицуулсан зарим харилцаа практикт нэгэнт хэвшсэн шинжтэй, зарим харилцаа нь шинэ харилцаа байна. Хуулийн төсөлд тусгасан шинэ зохицуулалтаас дурдвал, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан болон төслийн гүйцэтгэгчийг ажлын гүйцэтгэлээр нь үнэлэх болно. Одоогийн норм, нормативын санг өөрчлөн сайжруулан зохион байгуулах нь барилга, авто зам, төмөр зам болон эрчим хүчний салбарын технологийн хөгжлийг дэмжих, норм, нормативын баримт бичгийг шинэчлэх, боловсронгуй болгох, улмаар төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

Харин төслийн гүйцэтгэгчийг ажлын гүйцэтгэл, үр дүнгээр нь үнэлж ногоон, шар, улаан жагсаалтад хамруулах нь хуулийн төсөлд тусгасан шинэ зохицуулалт бөгөөд урамшуулал, хариуцлага нь хийсэн ажлын гүйцэтгэл, хүрсэн үр дүнд суурилсан байх зарчимд нийцсэн хэмээн үзнэ. Иймд, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг практикт хэрэгжих боломжтой хэмээн үзэв.

- **“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр**

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан нь тавигдаж буй шаардлагыг хангасан байна. Хуулийн төслийн зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар томъёолсон байна.

- **“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр**

Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт болон шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах явцад засаж сайжруулах боломжтой, асуудлыг илүү тодорхой болгох, анхаарах шаардлагатай дараах асуудал байна. Үүнд:

1. Энэхүү тайлангийн 4.3 дугаар хэсэгт шинжилсэнчлэн хуулийн төслийн дараах зохицуулалтыг засаж, илүү ойлгомжтой, тодорхой болгох:
 - 4 дүгээр зүйлийн 4.1.18 дахь заалтад “гэрээнд” гэснийг “төсөл хэрэгжүүлэх гэрээнд” гэж тодотгох, 4.1.19 дэх заалтын “баримт бичгийг” гэснийг “энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан баримт бичгийг” гэж өөрчлөх;
 - 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх шинжилгээнд” гэснийг “нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох шинжилгээнд” гэж өөрчлөх;
 - 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “төсвийн хөрөнгө оруулалтын” гэснийг “улсын төсвийн хөрөнгө оруулалтын” гэж өөрчилж хуулийн төслийн зүйл, заалтын хоорондох уялдааг хангах;
 - 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалтад “хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагын” гэснийг “олон улсын байгууллага, түнш орны” гэж, 18.2.5 дахь заалтад “хөгжлийн түншээс” гэснийг “олон улсын байгууллага, түнш орноос” гэж тус тус өөрчилж, хуулийн төслийн нэр томъёог Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн нэр томъёотой нийцүүлэх;
 - 29 дүгээр зүйлийн 29.4.3 дахь заалтын хүрээнд магадалшгүй ажлын зардлыг хэрхэн тодорхойлж төсөл хэрэгжүүлэх гэрээнд заах талаар зохицуулалтыг нэмж тусгах.
2. Хуулийн төслийн 8.2-т “улсын төсвийн хөрөнгө оруулалт” хэмээн тодруулан заасан тул төслийн 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” гэсэн нь давхардаж байх тул хасах нь зүйтэй байна;
3. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт “энэ хуульд зааснаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд” гэсэн нь ямар нөхцөл, журмаар нэмэлт санхүүжилт олгохыг тодорхой заагаагүй тул практикт төсөл хэрэгжүүлэгч этгээдийн зүгээс нэмэлт санхүүжилт шаардах үндэслэл, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн хүрээ тодорхойгүй байх эрсдэлтэй. Иймд, уг хэсэгт хуулийн аль зүйл, хэсэгт заасан тохиолдлыг хэлж буйг тодорхой эш татан заах шаардлагатай байна.
4. 15 дугаар зүйлийн гарчгаас “улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч” гэсэн хэсгийг хасах, төслийн 15.1.2, 15.1.5 дахь заалтыг нэгтгэн найруулах нь зүйтэй.
5. Захиргааны ерөнхий хууль, Иргэний хуулиар зохицуулагддаг тул хуулийн төслийн 16.3 дахь хэсгийг хасах асуудлыг дахин нягтлах шаардлагатай.
6. Хуулийн төслийн 18.2.2, 18.2.3 дахь заалтад I, II ангиллын төслийг зөвхөн орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бус улсын төсвийн болон хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх боломжийг нэмж тусгахыг зөвлөж байна.
7. Хуулийн төслийн 18.2.4-т “дэд бүтцийн буюу төсвийн хөрөнгө оруулалтын II - V ангиллын төсөл” гэжээ. Энэ нь хуулийн төслийн 7.4-т

- тодорхойлсон төслийн аль төрөлд хамаарах нь ойлгомжгүй байх тул “дэд бүтцийн буюу” гэдгийг хасахыг зөвлөнө;
8. Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3-т зардлын дээд хэмжээг ямар төсвөөс тооцох нь тодорхой бус байгааг тодорхой болгох. Төслийн зураг төсөл, төсөв хараахан гараагүй нөхцөлд төсөвт өртгийг ямар төсвөөс тооцох нь тодорхой бус болох бөгөөд зардлын дээд хэмжээ 3 хувиас хэтрэхгүй байх, ингэхдээ тухайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зардлын дээд хэмжээг бус зардлын хэмжээг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоохоор найруулах нь зүйтэй байна;
 9. Хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт хяналтын зардлыг буцаан төвлөрүүлэх талаарх зохицуулалтаар зохиогчийн болон техникийн хяналтын байгууллагууд аливаа төсөлд оролцохдоо шууд санхүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй болж, үүнээс үүдэн өндөр эрсдэлтэй, шинэлэг төслүүдэд оролцохоос татгалзах хандлагатай болох магадлалтай бөгөөд энэ нь мэргэшсэн, туршлагатай хяналтын инженер, зөвлөхүүдийн оролцоог бууруулах, төсөл хэрэгжүүлэх чанар, хяналтын мэргэжлийн түвшин доройтох үр дүнд хүргэх эрсдэлтэй гэдгийг анхаарах нь зүйтэй.
 10. Хуулийн төслийн 34.8 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага норм, нормативын сангаар хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, зардлын зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг тус тус” гэсэн хэсгийг хасах, эсхүл өөрчлөн найруулах нь зүйтэй. Түүнчлэн, холбогдох хууль, захиргааны актад захиалагчийн техник, технологийн хяналт гэх нэр томъёог ялгаатай тусгасан байх тул нийтлэг байдлаар ойлгох боломжтой нэр томъёог хэрэглэх нь зүйтэй.
 11. Хуулийн төслийн 35.3-т цахим системд мэдээллийг ил тод, нээлттэй байлгах гэж, 37.2-т цахим системийн удирдлага, зохион байгуулалт гэж тусгасан нь цахим системийн талаар давхардуулан зохицуулсан гэж үзэхээр байх тул давхардлыг арилгах нь зүйтэй.
 12. Хуулийн төслийн 42.1-д хөрөнгийн үр өгөөжийг тооцох үнэлгээг бүх ангилал, бүх төрлийн төсөлд хийх эсэх, ямар хугацаанд ямар давтамжтай хийх болон орон нутгийн оролцоо (Засаг дарга)-ны талаар судлан, нэмж тусгах нь үр нөлөөг нэмэгдүүлнэ.
 13. Хуулийн төслийн 47.1.2-т “төслийн хэрэгжүүлсэн хугацаа”, 47.1.3-т “төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй хэрэгжүүлсэн байдал” гэсэн хэсэг нь ойлгомжгүй байх тул 47.1.2-ыг “төсөл хэрэгжсэн хугацаа” гэж, 47.1.3-ыг “төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан байдал” гэж өөрчлөхийг зөвлөв.
 14. Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “улаан” жагсаалтын гүйцэтгэгч болон түүний хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд “шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр, эсхүл бусад хуулийн этгээдээр дамжуулан” оролцохыг хориглосон боловч энэ нөхцөлийг хэрхэн тогтоох нь, ямар хэмжээнд хязгаарлах нь тодорхойгүй байна. Хувьцаа эзэмшлийн хувь, оролцооны хэмжээг тодорхой зааж өгөөгүй нь маргаан үүсгэх эрсдэлтэй. Мөн энэ хоригийг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэгчийн хувьцаа эзэмшигчид, удирдлагын бүрэлдэхүүн, санхүүгийн хамаарал, гэрээний эрх, ашиг сонирхол зэрэг бүх холбоог

нарийвчлан шалгах шаардлага үүснэ. Гэтэл ийнхүү шалгалт хийх хүний нөөц, чадамж, практикт хэрэгжих боломж бий эсэхийг анхаарах нь зүйтэй юм.

-----oOo-----

ДОЛОО. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Иргэний хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;
- Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”;
- Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын дүрэм”;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн үзэл баримтлал;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;
- Улсын Их Хурлын цахим хуудас, www.parliament.mn;
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, www.legalinfo.mn

-----oOo-----